

"МАЛЧДЫН НИЙГМИЙН ХАМГААЛЛЫГ ӨРГӨЖҮҮЛЖ, ЦОЧРОЛД
ХАРИУ ҮЗҮҮЛЭХ БЭЛЭН БАЙДЛЫГ НЭМЭГДҮҮЛЭХ НЬ"
ХАМТАРСАН ХӨТӨЛБӨР

"MNS 6891:2020 –ХАРИУЦЛАГАТАЙ НҮҮДЭЛЧИН
ЗОХИСТОЙ ДАДЛЫГ НЭВТРҮҮЛЭХЭД ТАВИХ ШААРДЛАГА"
СТАНДАРТЫГ СУРТАЛЧЛАН ТАНИУЛАХ

ХЭРЭГЛЭГЧДЭД ЗОРИУЛСАН ГАРЫН АВЛАГА

УЛААНБААТАР ХОТ 2022 ОН

Агуулга

НЭГ.ОРШИЛ	4
1.1 Үндэслэл, ач холбогдол	4
1.2 Гарын авлагын тухай танилцуулга	5
1.3 Хариуцлагатай нүүдэлчин зохистой дадлыг нэвтрүүлэх үйл ажиллагаа	5
ХОЁР. СУРГАЛТАД БАРИМТЛАХ АРГА ЗҮЙ	6
2.1 Сургалтын онцлог, зарчим	6
2.2 Оролцогчдод өгөх нэмэлт мэдээлэл–1	6
2.2.1. Малын бэлчээрт тавих үндсэн шаардлага.	7
2.2.2. Малын тэжээллэг, арчилгаа, маллагаанд тавих үндсэн шаардлагууд	20
2.2.3. Малын эрүүл мэндэд тавигдах шаардлага	27
2.2.4. Малын нөхөн үйлдвэрлэл, үржүүлэг селекци–д тавих үндсэн шаардлага.	29
2.2.5. Малын гаралтай түүхий эд бэлтгэлд тавих үндсэн шаардлага.	31
2.3 Сургалтын арга зүй	36
2.3.1 Дөхүүлэх асуултын арга:	36
2.3.2 Бусад оролцогчдын санаа бодлыг сонсох, хариултыг хэлэлцүүлэг болгон өрнүүлэх арга:	36
2.3.3 Чиглүүлэх асуултууд;	36
2.3.4 Кейс тохиолдлыг задлан шинжлэх арга зүй:	42
ГУРАВ. СУРГАЛТЫН ЗОХИОН БАЙГУУЛАЛТ	44
3.1 Танхимын бус сургалт үйл ажиллагааны тухай	44
3.2 Харилцан суралцах аргаар сургалтыг зохион байгуулах нь:	44
ДӨРӨВ. СУРГАЛТЫН ДАРААХ ДҮГНЭЛТ, ҮНЭЛГЭЭ	51
4.1 СУРГАЛТЫН ҮНЭЛГЭЭНИЙ ХУУДАС	51

НЭГ.ОРШИЛ

Зохистой дадал гэж юу вэ?

Холбогдох стандарт түүнийг орлох баримт бичигт заасан шаардлагыг биелүүлэхэд чиглэсэн цогц үйл ажиллагааг зохистой дадал гэнэ.

Зохистой дадал нэвтрүүлэх зорилго юу вэ?

Малчид өөрийн үйлдвэрлэж байгаа бүтээгдэхүүнийхээ чанар, аюулгүй байдлын үзүүлэлтийг боловсруулах үйлдвэр болон хэрэглэгчдийн шаардлагад бүрэн нийцэж байгааг нотлох

1.1 Үндэслэл, ач холбогдол

Монгол улсын хөгжлийн урт хугацааны бодлогын баримт бичиг, “Алсын хараа 2050” –д нүүдлийн соёл иргэншлийг хадгалсан тэргүүлэх улс болно гэж зорилт дэвшүүлсэн байдаг.

Энэ зорилтын хэмжээнд бодлоготой эдийн засгийг бий болгоно гэж тусгасан байдаг. Мөн “Алсын хараа 2050” –ийн 1–р үе шат буюу 2020–2030 онд хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн нөөц ашиглалт, эдийн засгийн эргэлтийг эрчимжүүлэх, тооноос чанар, бүтээмжид шилжих үе гэж тодорхойлсон байдаг. Мөн органик түүхий эдийг тогтвортой эрхлэх, ХАА гаралтай түүхий эдийн бүтээгдэхүүний зорилтод зах зээлийг бэлтгэн нийлүүлэлтийн тогтолцоо дотоодын нэмүү өртгийн сүлжээг бий болгох зорилт арга хэмжээнүүд тусгагдсан.

Мөн МУ–ын хөгжлийн дунд хугацааны хөтөлбөрүүдэд “Монгол Мал”, “Монгол ноолуур” үндэсний хөтөлбөрт үндэсний үйлдвэрлэлийн дэлхийд өрсөлдөх чадварыг бий болгох зорилт тусгагдсан байдаг. Энэхүү ажлын уг стандартыг 12 бүлэгт хувааж, үндсэн зарчим нь уламжлалт нүүдлийн мал аж ахуйг нийгмийн зах зээлийн эрэлт хэрэгцээтэй уялдуулж, хариуцлагын тогтолцоог хөгжүүлэх, хариуцлагатай нүүдэлчид зохистой дадлыг сайн дурын үндсэн дээр хэрэгжүүлэх бөгөөд ажлын үр дүнг үнэлгээ баталгаажуулалт хийж, нийгмийн дунд хүлээн зөвшөөрөгдөж, үүргийн чиг үүргийг тусгаж өгсөн.

Мал аж ахуйн үйлдвэрлэл дээр таван гол зүйл дээр шалгуур тавихаар төлөвлөсөн. Малын бэлчээрийн хэсэг МБАНХ Н.Ганхуяг захирал, НАМЭМ төслийн зохицуулагч доктор Ц.Энх–Амаглан хамтран ажилласан. Малын арчилгаа маллагаанд тавигдах шаардлага: МАА эрдэм шинжилгээний хүрээлэнгийн доктор Удвал, Малын эрүүл мэндэд тавигдах шаардлага: Швейцарын хөгжлийн агентлагийн малын эрүүл мэнд хариуцсан менежер Дивангар, малын нөхөн үйлдвэрлэл, үржүүлэгт тавих шаардлага: Доктор Сувдаа, малын гаралтай түүхий эд бүтээгдэхүүнд тавих шаардлагыг боловсруулахад доктор, профессор Энхтуяа хамтран ажилласан.

Энэхүү стандартыг боловсруулаад, батлуулсны дараа ямар үр дүн хүлээгдэж байна вэ?

Үүнд:

Нүүдлийн мал аж ахуйг тогтвортой эрхлэх, бэлчээрийн мал аж ахуйн анхан шатны үйлдвэрлэл болох малын тавлаг байдлыг хангаж хариуцлагатай нүүдэлчин тогтолцоог хэрэгжүүлэх нөхцөлийг бүрдүүлэх, дэлхийн хэрэглэгчдийн шаардлагыг бүрэн хангасан гарал үүсэл нь тодорхой болгох, байгаль мал амьтанд ээлтэй түүхий эдийг ашиглаж байгаа гэдгийг баталгаажуулах стандарттай болсон байна.

Малчдад сургалт зохион байгуулах сургагч багш нар сургалтыг үр дүнтэй зохион байгуулж, амжилтад хүрэхийн тулд тэдний оролцоо, мэдлэг, туршлагад тулгуурласан арга зүйг сонгон хэрэглэх нь зүйтэй

юм. Сургагч багш нар оролцогчдын хэрэгцээ, мэдлэг, туршлагын түвшнийг харгалзаж, сургалтын агуулга, хөтөлбөрийг уян хатан байдлаар зохион байгуулж болно. Энэхүү сургагч багшийн гарын авлагад оролцоонд суурилсан сургалтын аргууд, амжилттай суралцахуйн зарчим болон практик, сайн сургагч багш байх зөвлөмж, зорилтот бүлгийн онцлогийг харгалзах асуудал, насанд хүрэгчидтэй ажиллах зөвлөмж, мал аж ахуйн үйлдвэрлэлийн зохистой дадлын стандартын танилцуулга хичээлийн заах арга зүйн талаар тусгасан болно.

1.2 Гарын авлагын тухай танилцуулга

“Хариуцлагатай нүүдэлчин зохистой дадлыг нэвтрүүлэхэд тавигдах шаардлага” модуль нь малчдад сургалт зохион байгуулах сургагч багшийн ашиглах гарын авлага бөгөөд багш нарт арга зүйн зөвлөгөө өгөх, сургалтыг хэрхэн үр дүнтэй зохион байгуулах арга замуудын үлгэрчилсэн төлөвлөгөөг шингээж өгснөөрөө онцлог юм.

Нүүдлийн мал аж ахуйг тогтвортой эрхлэх, бэлчээрийн мал аж ахуйн анхан шатны үйлдвэрлэл болох малын тавлаг байдлыг хангаж хариуцлагатай нүүдэлчин тогтолцоог хэрэгжүүлэх нөхцөлийг бүрдүүлэх, дэлхийн хэрэглэгчдийн шаардлагыг бүрэн хангасан гарал үүсэл нь тодорхой болгох, байгаль мал амьтанд ээлтэй түүхий эдийг ашиглаж байгаа гэдгийг баталгаажуулах стандарттай болсон байна.



Энэхүү модуль, гарын авлагын гол ач холбогдол нь Монгол орны бэлчээрийн мал аж ахуйг хөгжүүлэхэд мал, амьтны эрүүл мэндийг хамгаалж, тавлаг байдлыг хангах, байгаль орчин, бэлчээр, тэжээл, усны хангамжийг зөв зохистой ашиглах, малын үржүүлэг селекц, тэжээллэг, арчилгаа, маллагаа зэрэг мал аж ахуйн үйлдвэрлэлийг тогтвортой эрхлэхэд тавих зохистой дадлыг нэвтрүүлэхэд оршино. Иймд багш нар энэхүү агуулгыг малчдад хүргэхдээ тэдний арга, туршлагыг сонсох, амьдралын үнэт зүйл, мэдлэг чадвар дээр нь тулгуурлан хэлэлцүүлэг зохион байгуулах, хооронд нь сайн туршлагыг нь солилцуулах зэргээр арга зүйн шийдлүүдийг гаргаж ажиллах нь зүйтэй.

1.3 Хариуцлагатай нүүдэлчин зохистой дадлыг нэвтрүүлэх үйл ажиллагаа'

Үндсэн зарчим:

- Уламжлалт нүүдлийн мал аж ахуйн арга ажиллагааг нийгэм, эдийн засаг, зах зээлийн эрэлт хэрэгцээтэй уялдуулж боловсронгуй болгож, хариуцлагын тогтолцоог хөгжүүлэх;
- Хариуцлагатай нүүдэлчин зохистой дадлыг нэвтрүүлэхдээ мал аж ахуйн тогтвортой байдлыг хангах, малчид, боловсруулах үйлдвэрлэл эрхлэгчид, хэрэглэгчид зэрэг оролцогч талуудын харилцан итгэлцэл, үнэн зөв мэдээлэлд тулгуурлах;
- Хариуцлагатай нүүдэлчин зохистой дадлыг сайн дурын үндсэн дээр нэвтрүүлэх бөгөөд хэрэгжилтийн үе шатуудад үнэлгээ, баталгаажуулалтын үндсэн дээр нийгмийн дунд хүлээн зөвшөөрөгдөх;

ХОЁР. СУРГАЛТАД БАРИМТЛАХ АРГА ЗҮЙ

2.1 Сургалтын онцлог, зарчим

Сургалт гэдэг нь тухайн хүнд ажил, даалгаврыг гүйцэтгэхэд шаардлагатай ерөнхий болон тодорхой, мэргэжлийн мэдлэг, ур чадвар, туршлагыг хөтөлбөрийн дагуу олгодог зохион байгуулалттай үйл ажиллагаа юм. Энэхүү сургалтад малчин иргэд оролцох тул янз бүрийн насны, өөр өөр мэдлэг туршлагатай, өөр өөр түвшний мэдлэг мэдээлэлтэй хүмүүс

байгаа гэж үзээд гэж үзээд насанд хүрэгчдийн сургалтын арга зүйгээр зохион байгуулах нь зүйтэй юм. Насанд хүрэгчдийн сургалт нь ЕБС, дээд сургуулийн сургалтын арга зүйгээс ялгаатай. Иймд сургагч багш та сургалт зохион байгуулахдаа дараах зүйлсийг анхаарах хэрэгтэй.

1. Сургалтад оролцогчдын манлайлал, идэвхтэй оролцоо /Сургалтад оролцож байгаа малчин иргэдийн оролцоог бүрэн хангах, нүүр хагарах, багийн үйл ажиллагаанд манлайлан оролцох, санаа бодлоо чөлөөтэй илэрхийлэх сэтгэлзүйн болон үйлийн орчныг бүрдүүлж ажиллах/
2. Сургалтын орчин аюулгүй, тайван байх
3. Сургалтынматериалачхолбогдолсайтай,өгөөжтэйбайх/сургалтаарөгөгдөжбуйхэрэглэгдэхүүн санаа сэдэл үүсгэхүйц үр ашиг, өгөөжтэй байх, видео хичээл болон хэрэглэгдэхүүний ач холбогдлыг тооцоолон, хэлэлцэх асуулт бүрийг өгөөжтэйгөөр боловсруулах/
4. Хүртэхүйн олон тал хэлбэрийг ашиглан сургалтаа зохион байгуулах /Ярилцах, сонсох, оролцох, хийх, бүтээх, илтгэх. Оролцогч өөрөө хийж бүтээж, судалж илтгэсэн бүхэн эргээд хүнд тогтдог тул насанд хүрэгчдийн сургалтын арга зүйгээр оролцоог хангах, идэвхжүүлэх/
5. Практик хэрэглээ /Сургалтад авч буй жишээ, кейс тохиолдол амьдрал, практик, уламжлал, хэрэглээнд илүү ойр байх /
6. Эргэх холбоо
7. Сэдэл тэмүүлэл Сургалтад баримтлах арга зүйн гол шийдэл нь янз бүрийн насны малчин иргэдтэй харилцах учир ярилцлага болон хэлэлцүүлэг хэлбэрээр явуулбал илүү үр дүнтэй байх болно. Учир нь тэд өөрийн туршлагаа бусдад түгээх, санал бодлоо солилцох зэргээр хөгжих боломжтой.

2.2 Оролцогчдод өгөх нэмэлт мэдээлэл–1

Мал сүргийн тавлаг байдлыг хангах замаар бэлчээр ашиглах, малын арчилгаа маллагаа, үржүүлэг, селекцийг удирдан явуулах, эрүүл мэндийг хамгаалах болон малын гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг бэлтгэхэд тавигдах шаардлагыг хангахад зориулагдсан цогц үйл ажиллагааг хариуцлагатай нүүдэлчин зохистой дадал гэж ойлгоно.

Хариуцлагатай нүүдэлчин зохистой дадалд тавигдах шаардлагууд нь дараах баримт бичгээс бүрдэнэ.

Үүнд:

1. Малын бэлчээрт тавигдах шаардлага
2. Малын арчилгаа, маллагаанд тавигдах шаардлага
3. Малын эрүүл мэндэд тавигдах шаардлага
4. Малын нөхөн үйлдвэрлэл, үржүүлэг, селекцид тавигдах шаардлага
5. Малын гаралтай түүхий эд, бүтээгдэхүүн бэлтгэхэд тавигдах шаардлага

2.2.1. Малын бэлчээрт тавих үндсэн шаардлага.

1.Бүртгэл хөтлөлт, төлөвлөлт

- Бэлчээрт жил бүр мониторинг хийсэн байна.
- Бэлчээр ашиглагчдын хэсэг бүлгийн болон улирлын бэлчээрийн хэмжээ байршил тогтоосон байна.
- Бэлчээр ашиглах төлөвлөгөөг жил бүр газар зохион байгуулалтын тухайн жилийн төлөвлөгөөнд тусган ИТХурлаар батлуулж ажилладаг байна.
- Бэлчээр ашиглах журмыг сумын ИТХурлаар батлуулж, хууль зүйн яамны захиргааны хэм хэмжээний актын улсын бүртгэлд бүртгүүлнэ.
- Бэлчээр ашиглах гэрээг сумын Засаг даргатай байгуулсан байна.
- Бэлчээр ашиглах гэрээний хэрэгжилтийг жил бүр дүгнэсэн байна.

2.Бэлчээр зохион байгуулалт

- Бэлчээрийн голлох зүйл ургамлын эзлэх хувь хэмжээг гэрээ байгуулах үеийн тогтоосон суурь түвшингээс бууруулаагүй байна.
- Малчдын хэсэг, бүлгийн гэрээгээр ашиглаж байгаа бэлчээрийн ургац нэмэгдүүлэх, сайжруулах арга хэмжээг жил бүр хэрэгжүүлсэн байна.
- Малчдын хэсэг, бүлгийн гэрээгээр ашиглаж байгаа бэлчээрийн төлөв байдал сэргэх чадавхын үнэлгээгээр гэрээ байгуулсан үеийн түвшингээс буураагүй байна.
- Малын тоог бэлчээрийн даацад тохируулах арга хэмжээг хэрэгжүүлэхдээ бэлчээрийн даацыг тухайн экологийн бүсийн хэвийн хэмжээнээс хэтрүүлээгүй, бэлчээрийн ачаалал суурь жилтэй харьцуулахад нэмэгдээгүй байна.
- Бэлчээрийг тогтвортой ашиглах зорилгоор дараах арга хэмжээг авсан байна.
Үүнд:
 - Хэсэг, бүлгийн бэлчээрийг ашиглах улирлын хуваарь тодорхой байна.
 - Малчин өрхийн жилийн дундаж нүүдлийн тоо 4 ба түүнээс дээш байна.
- Бэлчээрийг тордох, хөрсний үржил шимийг сайжруулах, хөнөөлт мэрэгчидтэй тэмцэх, хог цэвэрлэх, хорт ургамалтай тэмцэх арга хэмжээг хамтын хүчээр зохион байгуулах, төсөв санхүүгийн эх үүсвэрийг бүрдүүлэхэд санаачилга гарган ажилласан байна. Бэлчээр, хадлангийн хөнөөлт мэрэгчидтэй “MNS 6866 : 2020 Мэрэгчидтэй тэмцэх арга” стандартыг мөрдөж ажиллана.
- Тэжээлийн ургамал тариалах, хадлангийн талбайг усжуулах, хашаажуулах, зэргээр малын тэжээлийн нөөцийг нэмэгдүүлсэн байна,
- Уст цэг бий болгох, хөв цөөрөм байгуулах, усны эх үүсвэрийг хамгаалах ажлыг хэрэгжүүлсэн байна.

3.Малчдын хамтын ажиллагаа

- Бэлчээр нутгаа уламжлалаараа хамтран ашиглаж ирсэн малчид хэсэг бүлэг, бэлчээр ашиглагчдын холбооны зохион байгуулалтад орсон байна.
 - Хэсэг бүлгийн хурлын 70–аас дээш хувьд оролцсон байна.
 - Хэсэг бүлэг бүх гишүүдийн хурлаар баталсан дотоод дүрэмтэй байна.
 - Дотоод дүрмээ бүх гишүүд баталж гарын үсэг зурсан байна.
- Малчдын хэсэг бүлэг талуудын эрх, үүргийг тодорхой тусгасан бэлчээр ашиглах гэрээг Засаг даргатай байгуулж жил бүр хэрэгжилтийг дүгнэсэн байна.
- Бэлчээр ашиглуулах гэрээ газрын кадастрын мэдээллийн санд бүртгэгдсэн эсэхэд хяналт тавьж ажилласан байна.

- Малчид хоршиж ажиллах замаар түүхий эд бэлтгэлийн анхан шатны хоршооны зохион байгуулалтад орсон байна.
- Гишүүд хоршоондоо мал, малын гаралтай түүхий эд, бүтээгдэхүүн тогтмол нийлүүлсэн байна.
- Бэлтгэсэн мал, малын гаралтай түүхий эд бүтээгдэхүүний анхан шатны тордолт хийх, нэмүү өртөг шингээх, зах зээлд нийлүүлэх зэргээр олсон орлого, ашгийг хоршооны гишүүд хүртсэн байна.
- Хоршоо нь түүхий эдээ бэлтгэх, тээвэрлэх, хадгалах, тордолт хийх, материаллаг баазыг бүрдүүлсэн байна.

А. Бүртгэл хөтлөлт, төлөвлөлт

Малын бэлчээрт тавих шалгуур шалгуурыг биелүүлэхийн тулд дараах мэдлэг мэдээллүүдийг сургалтад оролцогчдод нарийвчлан тайлбарлаж өгөх нь зүйтэй.

Бэлчээрт жил бүр мониторингийн судалгаа хийлгэж байх нь яагаад чухал вэ?

Малчин өрх, бэлчээр ашиглагчдын хэсэг бүлгийн хувьд өөрсдийнх нь амьжиргааны эх үүсвэр болсон бэлчээрийн газрын төлөв байдал одоо яг ямар хэмжээнд байна, ашиглалтын улмаас хэрхэн өөрчлөгдөж, доройтсон байна, доройтсон бэлчээр нь эргээд сэргэх боломжтой эсэх талаар бодитой мэдээлэлтэй байх нь юу юунаас чухал. Сумын газрын даамал жил бүр малчдын хэсэг, бүлгийн ашиглаж буй улирлын бэлчээр тус бүрд цэг сонгон фото мониторингийн аргаар судалгааг хийж байна. Фото мониторингийн шалгуур үзүүлэлтүүд нь бэлчээрийн газрын төлөв байдал, ашиглалтаас үүдэлтэй богино хугацааны өөрчлөлтийг цаг тухай бүр бодитой тодорхойлох, түүнд үндэслэн менежментийн горимыг тохируулах боломжийг олгодог. Иймд малчид, малчдын хэсэг бүлэг нь ашиглаж байгаа улирлын бэлчээр тус бүрд жил бүр судалгаа хийлгэж байх шаардлагатай юм.



Энэхүү асуултын хариуг сургалтад оролцогчдод тайлбарлаж өгөхийн тулд юун түрүүнд малчдын хэсэг, бүлгийн талаар товч мэдээлэл өгөх нь зүйтэй.

*Бэлчээр ашиглагчдын хэсэг бүлэг
нь хариуцан хамгаалж буй нийт
газар нутаг болон ашиглаж буй
бэлчээрийнхээ хэмжээ байршил,
заагийг хэрхэн тогтоох вэ?*

**Бэлчээр ашиглагч малчдын хэсэг, бүлгийн
талаарх товч ойлголт.**

Бэлчээрийг дундаа хамтран ашиглаж, үр шимийг нь хүртэж ирсэн малчин өрхүүд мал маллах арга ажиллагаа, нүүдлээ нутгийн онцлог, байгаль-цаг уурын өөрчлөлт, бэлчээрийн даац чадавхад нь тохируулан уян хатан зохицуулах, доройтлоос хамгаалах, сэргээн сайжруулах нийтлэг ашиг сонирхол, хил зааг, нутаг дэвсгэрийн харьяаллаар нэгдэн хамтын зохион байгуулалтыг бий болгодог. Энэхүү малчдын хамтын зохион байгуулалтыг “Бэлчээр ашиглагч малчдын бүлэг, хэсэг” хэмээн тодорхойлж байгаа бөгөөд бие биесээ сайн мэдэх, жилийн

хэд хэдэн улиралд айлсан нутаглаж бэлчээрээ хамтран ашигладаг малчин өрх нийлж малчдын хэсэг бүлгийг байгуулдаг. Дундын бэлчээрт үндэслэсэн малчдын хамтын зохион байгуулалт нь нэг талаас хөдөлмөр зохион байгуулалтыг боловсронгуй болгох, малчдын хоршилтыг хөгжүүлэх, шийдвэр гаргахад малчдын оролцоог нэмэгдүүлэх, байгалийн нөөцийг зүй зохистой ашиглах, хамгаалах, бэлчээрийн менежментийг хамтын удирдлагаар хэрэгжүүлэх хариуцлагын тогтолцоог бий болгох нөхцөлийг бүрдүүлэх нөгөө талаас малчдын хэсэг, бүлгийн хэрэгжүүлж буй үйл ажиллагаанаас хамааран тэдний бэлтгэж буй малын гаралтай түүхий эдийг тогтвортой хэмээн үзэх нөхцөл бүрдэх чухал ач холбогдолтой юм.

Иргэний хуулийн 481.1–д: “Хамтран ажиллах гэрээний үндсэн дээр хэд хэдэн этгээд холбоо болон нөхөрлөлийн хэлбэрээр зохион байгуулагдаж үйл ажиллагаа явуулж болох бөгөөд ийм байгууллагыг улсын бүртгэлд бүртгүүлэхгүй, бүтэц, зохион байгуулалтыг гишүүд харилцан тохиролцож тодорхойлно гэж заасныг үндэслэн малчдын хамтын зохион байгуулалтын нэг хэлбэр болох малчдын хэсэг, бүлгийг байгуулж, үйл ажиллагаа явуулж болох талаар зохицуулсан байдаг. Энэ хуульд заасан хамтран ажиллах гэрээг малчдын хэсэг, бүлгийн дотоод дүрмээр адилтган үзэж уг дүрэмд МАЛЧДЫН БҮЛЭГ, ХЭСЭГ–ийн бүтэц зохион байгуулалт, үйл ажиллагаа засаглалыг нарийвчлан тусгаж боловсруулан бүх гишүүдийн хурлаар хэлэлцэн баталдаг.

Энэ нь тухайн бэлчээр нутгийн малчин өрхийг ямар нэг ялгаварлалгүйгээр энэхүү бүтцэд заавал хамруулан бэлчээрийн хил заагийг тогтоож БИНХ–аар хэлэлцүүлэн дэмжүүлж, улмаар сумын Засаг даргын захирамжаар баталгаажуулдаг. Өөрөөр хэлбэл, малчдын хэсэг, бүлгийн ашиглаж буй бэлчээр нь малчдын дундын ашиглалтад байх бөгөөд ашиглах, хамгаалах шийдвэрийг нийтээр зөвшилцөж гаргах тул тухайн хил зааг дотор мал аж ахуйн үйлдвэрлэл эрхэлж буй өрх бүрд хамаатай, энэ агуулгаар тухайн бэлчээрийг ашигладаг бүх малчин өрх малчдын хэсэг, бүлгийн гишүүн байх шаардлагатай юм.

Бэлчээр зохион байгуулалтын арга хэмжээг хэрхэн төлөвлөж, хэрэгжүүлэх вэ?

Малчдын бүлэг, хэсэг, баг, сумын хэмжээнд бэлчээр зохион байгуулалтын арга хэмжээг төлөвлөж сумын газар зохион байгуулалтын тухайн жилийн төлөвлөгөөнд тусгуулж хэрэгжүүлж байх нь газрын зөрчил маргаанаас урьдчилан сэргийлэх, менежментийн үйл ажиллагааг хэрэгжүүлэх боломж бүрдэх юм.

Бэлчээрийн газрын ашиглалт хамгаалалтыг сайжруулахад авч хэрэгжүүлж буй технологи нийт нутаг дэвсгэрт нэлээд түгээмэл шинжтэй боловч аймаг сум бүрийн уламжлал, онцлог байдал, малын төрөл, газар зүй, байгаль, цаг уурын өвөрмөц байдлаас хамааран өөрийн онцлогтой.

Малчдын хэсэг бүлэг нь бэлчээрийн менежментийн төлөвлөгөөнд бүлгийн бэлчээрийн хил зааг, малчдын дөрвөн улирлын байршил, нүүж суух хугацаа, доройтсон бэлчээрийг сайжруулах, нөхөн сэргээх, сэлгэж ашиглах хуваарь, ургамал ургалтын хугацаанд чөлөөлж өнжөөх, хадлангийн талбайг хамгаалах, тордож сайжруулах, тэжээл бэлтгэх, худаг ус шинээр гаргах, засварлах, бэлчээрийн хөнөөлт мэрэгчидтэй тэмцэх, малын эрүүл мэндийг хамгаалах, үүлдэрлэг чанарыг сайжруулах зэрэг бүхий л чиглэлээр хэрэгжүүлэх үйл ажиллагааг тусгаж тухайн ажлуудыг хариуцах эзэн, хэрэгжүүлэх хугацаа, шаардагдах зардал зэргийг тооцож, боловсруулна.

Малчдын бүлэг, хэсгийн бэлчээрийн менежментийн төлөвлөгөөг Монгол улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.1 дэх хэсэг, Газрын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.1.1 дэх заалт, Газрын тухай хуулийн 52 дугаар зүйлийн 52.2 дах заалтуудыг үндэслэн Багийн Иргэдийн Нийтийн хурлаар хэлэлцүүлэн гаргасан саналыг нэгтгэж сумын газар зохион байгуулалтын тухайн жилийн төлөвлөгөөнд суулгаж, батлуулах ажлыг сумын Бэлчээр ашиглагчдын холбоо, баг, сумын Засаг дарга нар, холбогдох мэргэжилтнүүд хариуцан хэрэгжүүлнэ. сумын тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөний төслийг сумын ИТХурал хэлэлцэж баталснаар төлөвлөгөө сумын түвшинд эцэслэн баталгаажна.

Ихээхэн талхлагдсан бэлчээрийг улс, орон нутгийн болон гадаад, дотоодын төслийн хөрөнгө оруулалтаар сэргээхээс гадна бэлчээрийг сэлгэж ашиглалтаас чөлөөлөх байдлаар нөхөн сэргээх нь хамгийн тохиромжтой арга юм. Иймээс талхагдал, доройтол, элэгдэл, эвдрэлд орсон бэлчээрийн төрх, төлөв байдал, байршлыг тодорхойлж сайжруулалтын оновчтой аргуудыг тухайн төлөвлөгөөнд тусган хэрэгжүүлэх нь чухал юм.

Сумын бэлчээр ашиглалтын төлөвлөгөөний хэрэгжилтийг хэрхэн зохион байгуулах вэ?

Сумын бэлчээр ашиглалтын төлөвлөгөөний хэрэгжилтийг зохион байгуулах ажлыг сумын засаг даргын захирамжийн дагуу сумын газрын даамал, бэлчээрийн менежментийн ажлын хэсэг, малчдын бүлэг, хэсэг-ийн ахлагч, малчидтай хамтран хэрэгжүүлнэ.

Төлөвлөгөөний хэрэгжилтийг дараах байдлаар зохион байгуулна. Үүнд:

Олон нийтэд сурталчлах, үйл ажиллагааг зохион байгуулах:

Батлагдсан төлөвлөгөөг Иргэн, Аж ахуйн нэгж, малчид, малчдын бүлэг, хэсэг-т танилцуулах, сурталчлах ажлыг БИНХ, сум багийн өдөрлөг, малчдын хэсэг, бүлгийн хурал, малчдын уулзалт зөвлөгөөн, малчдад нэгдсэн болон хэсэгчилсэн сургалтуудаар дамжуулан зохион байгуулах.


Орчин үеийн техник технологи сошиал мэдээ мэдээллийн хэрэгслүүдийг ашиглан түгээн дэлгэрүүлэх:

Сумын болон багийн төвүүд дээр мэдээ мэдээллийн самбар байрлуулах, малчдын хэсэг, бүлгийн өнжөөж амрах, сэлгэж ашиглах бэлчээрийн талбайд таних тэмдэг, сануулга, самбар байрлуулах зэрэг.

Төлөвлөгөө хэрэгжүүлэхтэй холбоотой шийдвэр гаргах, хэрэгжилтийг зохион байгуулах:

Сумын Засаг дарга төлөвлөгөөнд тусгасан үйл ажиллагааг хэрэгжүүлэхтэй холбоотойгоор захирамж шийдвэрийг гаргаж нийтээр дагаж мөрдүүлэх.

Жишээ нь малчид малчдын бүлэг, хэсэг-ийн саналыг үндэслэн бэлчээрийн газрыг гэрээгээр ашиглуулах, улирлын бэлчээрийг ашиглах хуваарь, өнжөөж амрах бэлчээрт мал оруулах гаргах хугацаа, өвөлжөө хаваржааны доорх газрыг эзэмшүүлэх, сумын отрын нөөц нутаг ашиглах, өвөлжилтийн бэлтгэл хангуулах гэх мэт төлөвлөгөөг хэрэгжүүлэхтэй холбогдох үйл ажиллагааны чиглэлээр захирамж шийдвэр гаргах.



Бэлчээр ашиглалтын гэрээг хэрхэн байгуулах вэ?

Бэлчээрийг зохицуулалтгүй, дураар ашиглаж ирсэн зохисгүй хандлагыг хумих, экологийн тэнцвэрийг хадгалах үүднээс бэлчээрийн харилцааны зохицуулалтыг сайжруулах, хариуцлагажуулах, бэлчээрийн ачааллыг зохистой түвшинд барих нөөц бэлчээртэй байж, цаг агаарын хүндрэлийн үед гарах хохирлыг бууруулах, малчдын бэлчээр ашиглаж ирсэн уламжлалт эрхийг баталгаажуулаг гол арга механизм бол бэлчээр ашиглалтын гэрээ байгуулж хэрэгжүүлэх, өөрөөр хэлбэл, бэлчээрийг малчдад урт хугацааны гэрээгээр ашиглуулах явдал мөн.

Газрын тухай хуулийн 52.2, 52.4, 52.5 дахь заалт, Иргэний хуулийн 195–199 дүгээр заалт бэлчээрийг малчдад гэрээгээр ашиглуулах эрх зүйн үндэслэл болгоно. Бэлчээр ашиглалтын гэрээ нь шинээр газар олгох тухай биш, харин малчин өрхийн бэлчээр ашиглаж ирсэн уламжлалт эрхийг хүлээн зөвшөөрч баталгаажуулахад чиглэнэ. Нийгмийн зөрчил болон маргаантай асуудал гаргахгүй байх, үүний тулд малчин өрхийн газар ашиглалтын албан

бус эрхийг зохих ёсоор хүндэтгэн зөвшөөрч, бүртгэлжүүлэхэд гэрээ тулгуурлана. Бэлчээр ашиглалтын гэрээ нь малчдын бүлэг, хэсэг-ийн түвшинд улирлын нүүдэл ба урт хөлийн малын бэлчээр нутгийг зохицуулах, түүнчлэн мал сүргийн бүтэц, чанарыг сайжруулах замаар бэлчээрийн ачааллыг зохицуулах үйл ажиллагааны нягт уялдаа, харилцан хамаарал дээр тулгуурласан болно.

Бэлчээрийг гэрээгээр ашиглуулахад доорх зарчмуудыг баримтална:

- Гэрээг Газрын тухай хуулийн дагуу гэрээг бэлчээр ашиглагчдын хэсэг (малчдын бүлэг, хэсэг), малчдын бүлэг/нөхөрлөлтэй байгуулна.
- Малчдын байгууллагын гишүүн бус эсэхээс үл хамааран бэлчээр нэгтэй малчин өрхийг бэлчээр ашиглагч мөн гэсэн үндэслэлээр нийтээр нь гэрээ байгуулахад хамруулах. Учир нь ямар ч малчны бэлчээрээ ашиглах эрхийг хасах эрх хэнд ч байхгүй юм.
- Ган, зуд зэрэг байгалийн гамшиг болоход харилцан орж гарах нь нээлттэй байх, гэхдээ малаа оруулахдаа учиртай, бэлчээрийн даацыг нь тооцдог байх.
- Гэрээгээр ашиглах бэлчээрийн байршил, хил зааг нь бэлчээр ашиглаж ирсэн уламжлал, нутаглахуйн одоогийн хэв маягт суурилсан байх.
- Хөрш нутагладаг малчдын бэлчээр ашиглах эрхийг хүндэтгэх, өөрийн эрхийг хүндэтгүүлэх
- Отрын нөөц нутаг, ил задгай ус, хужир мараа зэрэг онцгой газрыг сум, багийн мэдэлд авч үлдэх.

Бэлчээр ашиглах урт хугацааны гэрээ байгуулахын гол ач холбогдол бол:

- Малчдын бэлчээр нутгаа ашиглаж ирсэн уламжлалт эрх баталгаажна.
- Бэлчээрийн харилцаанд оролцогч талуудын үүргийг тодруулж баталгаажуулж улмаар бэлчээр хариуцан хамгаалах эзэнтэй болно.
- Нийтийн бэлчээрийн эмх замбараагүй ашиглалтыг зогсоох, хариуцлагажуулах нөхцөл бүрдэнэ.
- МАА-н үйлдвэрлэлийн үр өгөөж, тогтвортой байдал сайжрах нөхцөл бүрдэнэ.
- Малын гаралтай бүтээгдэхүүний үнэлэмжийг нэмэгдүүлж улмаар малчин өрхийн орлого нэмэгдэж баталгаажна.

Бэлчээр ашиглах урт хугацааны гэрээ байгуулахын гол ач холбогдол бол:

Малчдын хэсэг бүлэг нь дараах алхам дарааллаар бэлчээр ашиглалтын гэрээг сумын Засаг даргатай байгуулна. Үүнд:

Алхам 1: Малчдыг хамтын зохион байгуулалтад оруулах, ахлагч сонгох, хэсэг бүлгийн хурал хийх

Бэлчээр ашиглагчдын хэсэг, бүлгийн гишүүнчлэлийн асуудлыг шийдэхдээ тухайн бэлчээр нутагт айл саахалт нутагладаг малчид уулзаж хамтарч хэсэг, бүлгийн зохион байгуулалтад орох боломж, дундын бэлчээр ашиглалт, хамгаалалтыг хамтдаа зохион байгуулах хэрэгцээ, давуу талуудын талаар хэлэлцэж, ахлагчаа сонгоно. Гэрээгээр

ашиглахаар санал болгосон бэлчээр дотор бүлэг, хэсэгт нэгдээгүй өрх үлдэх ёсгүйг онцгой анхаарах хэрэгтэй. Аль нэг өрхийг хүчээр нүүлгэн шилжүүлэх замаар асуудлыг шийдвэрлэж болохгүй учраас малчдад зөв ойлголтыг өгөх, нэгдсэн ойлголтод хүргэх үүднээс уулзалт зөвлөгөөнийг хэд хэдэн удаа зохион байгуулах шаардлагатай.

Алхам 2: Гэрээгээр ашиглах бэлчээрийн хил заагийг тогтоох, зөвшилцөх

Хэсэг, бүлгийн гишүүнчлэлийн асуудлыг шийдвэрлэсний дараа гэрээгээр ашиглах бэлчээрийн хил заагийг тогтооно. Ингэхдээ одоогийн ашиглаж байгаа улирлын бэлчээр, өвөлжөө, хаваржаа, худаг, уст цэгээ гэрээт бэлчээрийн зааг дотор багтаах нь зүйтэй. Улирлын бэлчээр нь аль болох нэг дороо буюу ойрхон байвал сайн. Гэрээгээр ашиглах бэлчээрийн хил заагийг хэсэг, бүлгийн нийт гишүүн өрхийг байлцуулан хэлэлцэж тогтооно. Гэрээгээр ашиглах бэлчээрийн заагийг байгалийн тодорхой объектоор /газрын гадаргуу, даваа, овоо, уул, ус, нуруу, нам хотос, хөтөл, ой мод, гол мөрөн, жалга, зам г.м/ зураг

дээр тэмдэглэнэ. Хил зааг доторх өвөлжөө, хаваржаа, зуслан, намаржаа, худаг уст цэг, гол, булаг, горхи, зам, шугам сүлжээ зэрэг объектуудыг оруулж зурна. Хил заагийг газар зүйн байршил тодорхойлогч GPS багажаар хэмжиж, координатыг нь тэмдэглэн баталгаажуулбал сайн. Гэрээгээр ашиглах бэлчээрийн хил заагийг тогтоож зурагласны дараа хөрш зэргэлдээх малчидтай зөвшилцөнө. Хэсэг, бүлгийн хилийг зэргэлдээх малчид, малчдын бүлэг хүлээн зөвшөөрч байгааг харуулсан баримт, энэ талаар хэлэлцсэн уулзалт, хурлын тэмдэглэл дээр гарын үсэг зуруулж баримтжуулна.



Алхам 3: Бэлчээр ашиглалтын гэрээ байгуулах

Гэрээгээр ашиглах бэлчээрийн хил зааг, гишүүн өрхүүд тодорхой болсноор тухайн бэлчээрийн экологийн чадавх, бэлчээрийн төлөв байдал, бүтээмжийн одоогийн түвшинг тодорхойлох, улмаар гэрээт бэлчээрийн хэмжээ, боломжит даац болон одоогийн ачаалал, мөн даацаас хэтэрсэн малын тоог тооцож гаргах боломж бүрддэг.

Бэлчээр ашиглуулах ИТХ-ын 11 дугаар тогтоолын гэрээний хавсралт № 01

Бэлчээр ашиглалтын гэрээнд гарын үсэг зурсан өрхийн төлөөллийн
нэрсийн жагсаалт /2016 оны 09 сарын 17 -ний өдөр/

"Тамч" БАХ-ийн бэлчээр ашиглагч өрхийн эрэгтэй, эмэгтэйтөлөөлөл

№	Гарын үсэг зурсан хүний овог	Гарын үсэг зурсан гишүүний нэр	Регистр	Харьяа баг (Нэрээр)	Малын тоо	Гарын үсэг
1	Норевс	Танбоомар	20 65061015	Тамч	1200	Танбоомар
2	Сүх	Богинмын	20 78052912	Тамч	1860	Богинмын
3	Ходоо	Бүтмэл	24 78022203	Тамч	1860	Бүтмэл
4	Галав	Монголбаяр	24 79031311	Тамч	489	Монголбаяр
5	Дамдинсүрэн	Бүтмэл	24 08052115	Тамч	350	Бүтмэл
6	Нэгэ	Ня.Осор	24 78091015	Тамч	1000	Ня.Осор
7	Монголсүр	Монголсүр	24 81042808	Монгол	1000	Монголсүр
8	Ня.түх	Осор	24 87012513	Тамч	300	Осор
9	Зогдбаатар	Зогдбаатар	24 78120300	Тамч	500	Зогдбаатар
10	Гонбоомар	Согдбаатар	24 92100416	Тамч	950	Согдбаатар
11	Мхалин	Хатанболд	24 84021913	Тамч	750	Хатанболд
12	Мхалин	Отгонбаяр	24 79111201	Тамч	350	Отгонбаяр
13	Монголсүр	Хэрлүү	24 77122113	Тамч	350	Хэрлүү
14	Танбоомар	Согдбаатар	24 92100416	Тамч	950	Согдбаатар
15	Онсүх	Бүтмэл	25 93122015	Тамч	400	Бүтмэл
16	Сүх	Ня.Осор	24 82100616	Тамч	852	Ня.Осор
17	Зогдбаатар	Тамч	24 87020702	Тамч	852	Тамч
18	Сүх	Богдбаатар	25 61070709	Тамч	400	Богдбаатар
19	Монголсүр	Монголсүр	24 83021616	Тамч	500	Монголсүр
20	Монголсүр	Монголсүр	24 68192513	Тамч	1000	Монголсүр
21	Монголсүр	Монголсүр	24 72072009	Тамч	1000	Монголсүр
22	Монголсүр	Монголсүр	24 59070210	Тамч	630	Монголсүр

Бэлчээр ашиглуулах 061007 тоот гэрээний хавсралт № 02.

Гэрээгээр ашиглуулах бэлчээрийн газрын байршил, улирлын хуваарь

Бэлчээр ашиглуулах 061007 тоот гэрээний хавсралт № 03

Бэлчээрийн газрын гэрээт талбайн экологийн чадавхийн зураг, бэлчээрийн төлөв байдал, шилжилтийн загвар, "Тамч" БАХ-ын бэлчээр ашиглагчдын хэсэг

Энэхүү зургаас үзэхэд "Тамч" БАХ-ын бэлчээрийн нийт газар 71057 га талбайтай. 8. Хөнгөн шавранцар хөрстэй уулын бэл хөндийн Крыловын хялгана-хазаар өвст бэлчээр, 14. Чулуурхаг хөрстэй тэгшивтэр тал хөндийн Өдлөг хялгана-үетэнт бэлчээрт тус тус байна.

Хүснэгт 01: Тамч БАХ-ийн өвөлжөөний бэлчээр нь төлөв байдал нь 8. Хөнгөн шавранцар хөрстэй уулын бэл хөндийн Крыловын хялгана-хазаар өвст бэлчээр



Хүснэгт 02: ТАМЧ БАХ-ийн хаваржааний бэлчээрийн төлөв байдал нь 8. Хөнгөн шавранцар хөрстэй уулын бэл хөндийн Крыловын хялгана-хазаар өвст бэлчээр



Хавсралт 4.

Бэлчээр ашиглуулах 061007 тоот гэрээний хавсралт № 04

Гэрээний энэхүү хавсралт нь гэрээний биелэлтийг, өөрөөр хэлбэл гэрээт ашиглагчид бэлчээрийг хэрхэн зүй ашиглаж буйг үнэлэх суурь мэдээлэл болох бөгөөд гэрээт бэлчээрийн газрын төлөв байдлын лавлагаа түвшний экологийн бүлэг бүрээр гаргасан мэдээллийг Төлөв байдал, шилжилтийн загвар дээр үндэслэн тодорхойлох бөгөөд суурь түвшний мэдээллийг гэрээ байгуулсан даруйд фото мониторингийн аргаар тодорхойлно. Цаашид тухайн тогтсон цэг дээр, тогтсон хугацаанд давтан үнэлгээ хийж мэдээллийг санд оруулан боловсруулалт хийж ашиглана.

Хүснэгт 01 Тамч бэлчээр ашиглагчдын хэсгийн өвөлжөөний бэлчээрийн үр дүн:

Аймгийннэр:	ГовьАлтайаймаг				
Сумыннэр:	Тонхил сум				
БАХ-ыннэр:	Тамч БАХ				
Ашигладагулирлыннэри йгбичнээү	Өвөлжөө				
Байгалийнбүс, бүслүүр (дугуйлнауу)	Цөлийн хээрийн				
	2015	2016	2017	2018	2019
Нийтбүрхэц	21.60	16.44			
Монголөвсбүрхэц, %					
Бусадүетэнбүрхэц, %	3.7	6.33			
Сөөг, сөөгөнцөрбүрхэц, %	6.9	4.11			
Таанабүрхэц, %					
Нэгнастбүрхэц, %					
Алагөвсбүрхэц, %	10.8	6			
Халцгайгазарбүрхэц, %					
Хагдбүрхэц, %					
Бусадбүрхэц, %		83.55			
Ургац, кг/га	297.6	275.33			
Нийтмалынтоо, мян.толгой	1851	28405			
Нийтмалынтоо, хонинтолгойдшилжүүлс нээр	2166	35155			
Боломжитдаац, хт/га	569	13022			
Даацаасхэтэрсэнмалын тоо	-1596	-25,947			
Бэлчээрийнтөлөвбайдал өөрчлөлтийнзагварынду гаар	14,1	14,1			
Төлөвбайдлыннэр	Чулуурхаг хөрстэй тэгшивтэр тал хөндий өдлөг хялгана үетэнт бэлчээр	Чулуурхаг хөрстэй тэгшивтэр тал хөндий өдлөг хялгана үетэнт бэлчээр			

Алхам 5. Бэлчээр ашиглалтын гэрээний хэрэгжилтийг зохион байгуулах

- Бэлчээр ашиглалтын гэрээг хэрэгжүүлэх ажлын хүрээнд малчдад доорх чиглэлүүдээр тодорхой мэдээлэл хүргэж ойлгуулах:
- Гэрээт бэлчээрийн төлөв байдал, чанарын суурь түвшин, түүний жил бүрийн мониторингийн дүнтэй хэрхэн харьцуулагдах, энэ мэдээлэл нь гэрээний хэрэгжилтийг үнэлэх суурь үнэлгээ болох
- Бэлчээр ашиглалтын гэрээний хэрэгжилтийг эрчимжүүлэх зорилгоор бэлчээрийн сайн дурын хураамж нэвтрүүлэн бэлчээр хамгаалах сан байгуулах, улмаар бэлчээрийн дэд бүтцийг сайжруулах, шаардлагатай үед нэмэлт тэжээл авах зэрэг цаг үеийн ажлуудад дэмжлэг үзүүлэх санхүүгийн тогтвортой эх үүсвэр бүрдүүлэх зэрэг дэмжих арга хэмжээний хөтөлбөр гаргаж ажиллана.
- Бэлчээр ашиглалтын гэрээг хэрэгжүүлэх төлөвлөгөө гаргаж түүндээ гэрээний хавсралт мэдээлэл дэх бэлчээр ашиглалт, бэлчээрийн сэлгээ, сайжруулалт, мөн мал сүргийн бүтцийг сайжруулах, ачааллыг тохируулах зөвлөмжийг хэрэгжүүлэх арга зам, санхүүгийн боломжит эх үүсвэрүүдийг тусгасан байна. Энэхүү төлөвлөгөөг хэрэгжүүлэхдээ тодорхой ажлууд дээр төслийн санал боловсруулан, Баг, сумын дэргэдэх бэлчээр хамгаалах сангаас санхүүжүүлэх хүсэлтээ хүргүүлнэ. Мөн малчдын бүлэг, хэсэг, багийн ИНХ–аар дамжуулан СГЗБТЖ төлөвлөгөөнд тусгаж ОНХ сангаас төсөв суулгах боломжтой.
- Бэлчээр ашиглалтын гэрээг хэрэгжүүлэх эрх зүйн зохицуулалтыг баталгаажуулахад сум, баг, малчдын бүлэг, хэсэг–ийн бэлчээр ашиглалтын журам чухал үүрэгтэй. Бэлчээр ашиглалтын журамд бэлчээр ашиглалтын гэрээний хэрэгжилтийг үнэлэх, илэрсэн зөрчилд арга хэмжээ тооцох, ашиглалтын горим, ачааллыг зөв тохируулж, бэлчээр нь сайжирсан малчдын бүлэг, хэсэг–ыг урамшуулах хэм хэмжээ, хариуцагчийг тодорхой тусгасан байна.

Алхам 6. Бэлчээр ашиглалтын гэрээний хэрэгжилтийг дүгнэх

1. Бэлчээр ашиглалтын гэрээний хэрэгжилтийг жил бүрийн фото мониторингийн дүн дээр үндэслэн үнэлж малчид болон орон нутгийн удирдлага, СЗДТГ, СИТХ, БМ ажлын хэсэг, мөн багийн болон МАЛЧДЫН БҮЛЭГ, ХЭСЭГ–ийн хурлаар танилцуулан хэлэлцүүлж ирэх жилийн төлөвлөгөөнд зохих өөрчлөлт, тодруулга хийж ажиллана.

2. Бэлчээр ашиглалтын гэрээний хэрэгжилтийг хангах, бэлчээрийн менежментийн үр нөлөөг хянаж үнэлэх ажлыг сумын газрын даамал Газрын Харилцаа, Геодези, Зураг Зүйн Газрын даргын 2015 оны А/105 тоот тушаалаар батлагдсан журамд заасан арга аргачлалыг баримтлан гүйцэтгэнэ. Бэлчээр ашиглалтын гэрээний хэрэгжилтээс хамааран сайн ажилласан малчдын бүлэг, хэсэг–ыг урамшуулж, гэрээний заалтыг зөрчсөн, малын тоо ачааллыг бэлчээрийн даац чадавхад тохируулаагүй, бэлчээрийг доройтуулж хохирол учруулсан этгээдэд сум, багийн бэлчээр ашиглалтын журмыг баримтлан хариуцлага хүлээлгэнэ.

Бэлчээр ашиглах журмыг сумын хэрхэн боловсруулж, ИТХурлаар батлуулж, хууль зүйн яамны захиргааны хэм хэмжээний актын улсын бүртгэлд бүртгүүлэх вэ?

Өнөөгийн нөхцөлд бэлчээр ашиглалтыг зохицуулах бие даасан хууль эрх зүйн орчин хангалтгүй байгаагийн улмаас доройтол, талхагдал, эмх замбараагүй ашиглалт нэмэгдсээр байна. Сум орон нутаг өөрсдөө бэлчээр нутгаа хамгаалах, зүй зохистой ашиглах талаарх тулгамдаад байгаа асуудлаа хэлэлцэн шийдвэрлэж малчдыг бүлэг, хэсгийн зохион байгуулалтад оруулах, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас баталсан бэлчээр ашиглалтын төлөвлөгөөний дагуу тэдэнд ялангуяа өвөлжөө, хаваржааны бэлчээрийг Газрын тухай хуулийн 52.2-т заасныг үндэслэн улирлын хуваарьтайгаар болзол, гэрээгээр ашиглуулах, улмаар бэлчээрийг хамгаалах, зүй зохистой ашиглахад аймаг,

сум, багийн нутгийн удирдлагын хэрэгжүүлэх үйл ажиллагаа, малчдын үүрэг, хариуцлагыг тодорхой болгох зайлшгүй шаардлагатай юм. Үүний тулд бэлчээр ашиглалт, хамгаалалт, хариуцлагын асуудлыг аймаг сумын хэмжээнд журмаар зохицуулах боломжтой юм. Бэлчээр ашиглалтын журмыг газрын тухай хуулийн 52.6 дахь заалтыг үндэслэн бусад хууль эрх зүйн хүрээнд зөрчилдчихөөгүйгээр боловсруулах шаардлагатай юм. Сумын хэмжээнд хэрэгжүүлэхээр боловсруулсан журам нь нийтээр ижид тэгш эрхтэйгээр дагаж мөрдөх захиргааны хэм хэмжээний акт учир хууль зүй дотоод хэргийн ямаар хянуулж захиргааны хэм, хэмжээний актын улсын бүртгэлд бүртгүүлэх зайлшгүй шаардлагатай юм.

Журам боловсруулж батлуулах үе шат дараалал

1. Орон нутгийн онцлог, үүсэж буй асуудал, бэрхшээл, шийдвэрлэх арга замуудыг тодорхойлох
2. Шийдвэрлэхээр тодорхойлсон асуудлуудыг одоо мөрдөгдөж буй хууль, эрх зүйн хүрээнд шийдвэрлэх боломжуудыг судална
3. Аймаг, сумын хэмжээнд бэлчээрийн газрын ашиглалт хамгаалалтыг хуулийн хүрээнд зохицуулах боломжтойгоор журмын төслийг боловсруулна
4. Олон нийтэд хэлэлцүүлэг хийж санал авах
5. Тухайн шатны ИТХ-аар хэлэлцүүлж батлуулах
6. Журмыг баталснаас хойш ажлын 5 өдрийн дотор хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлж хянуулах, Хянаж бүртгэсэн өдрөөс хойш 10 өдрийн дотор “Захиргааны хэм хэмжээний актын эмхэтгэл”-д бүрэн эхээр нь нийтлүүлнэ.

Бэлчээр ашиглах журмыг зөвхөн улсын нэгдсэн бүртгэлд бүртгэж, “Захиргааны хэм хэмжээний актын эмхэтгэл”-д нийтлүүлсний дараа хүчин төгөлдөр дагаж мөрдөнө.

2.2.2. Малын тэжээллэг, арчилгаа, маллагаанд тавих үндсэн шаардлагууд

Малын арчилгаа, маллагаа:

- Малын төрөл, нас, хүйс, ашиг шимийн чиглэл, бүс нутгийн экологийн онцлог, анатоми, физиологийн хэрэгцээ, шаардлагыг хангасан өвөлжөө, хаваржааны зориулалтын хашаа, саравч, хороо, байртай байна.
- Зун, намрын зөөврийн хашаа, тоног төхөрөөмжтэй байна.
- Малын хэвтэр бууц, хашаа хороог байнга цэвэр байлгана.
- Оны эхний малд зүй бусаар хорогдсон том малын эзлэх хувь /сүүлийн 3 жилийн дунджаар/
- Бод малд 4 хүртэл хувь,
- Бог малд 6 хүртэл хувь.
- Малд айдас дарамт үзүүлэх арчилгаа, маллагааны технологиос татгалзсан байна.

Малын бэлчээр, тэжээлийн хангамж, хүрэлцээ, тэжээллэг:

- Малын амьдралын болон ашиг шимийн хэрэгцээ шаардлагыг хангахуйц бэлчээр, тэжээлийн нөөцийг төлөвлөж хэрэгжүүлнэ. Мал сүргийг жилд 300–аас дээш хоногийн хугацаанд байгалийн бэлчээрт бэлчээрлүүлнэ.
- Өвөлжилт, хаваржилтад зориулж малд өгөх өвс, нэмэгдэл тэжээл бэлтгэж нөөцлөх ба 90–ээс доошгүй хоногт хүрэлцэхүйц байна.
- Бүс нутгийн онцлогтой уялдуулж малд давс, хужир зэрэг эрдэс тэжээл өгч, бүртгэл хөтөлсөн байна.
- Малын нэмэгдэл тэжээлийн чанар, эрүүл ахуйн шаардлага хангасан талаарх үйлдвэрлэгч болон нийлүүлэгчийн баталгаатай байна.
- Хадлан, тэжээлийн ургамал тариалалтад зөвхөн органик бордоог зааврын дагуу хэрэглэнэ.
- Малыг физиологийн норм, жорын дагуу тэжээх ба өлдөөхгүй цангаахгүй байна.

Малын усан хангамж:

- Малчдын бүлэг, хэсэг нь чанар, эрүүл ахуйн шаардлага хангасан усан хангамжийн эх үүсвэрийг бүрдүүлсэн байна.
- Усны чанар, эрүүл ахуйн үнэлгээг зохих байгууллагаар хийлгэсэн байна.
- Уст цэг, худаг, хөв цөөрөм бий болгох, сэргээн засварлахад хөрөнгө оруулалт хийнэ.

Мал хариулах, туух, тээвэрлэх үеийн аюулгүй ажиллагаа:

- Малаа хариулах, тууварлахдаа айдас, дарамт учруулахгүй, мотоцикл, машин ашиглахгүй, ердийн хөсөг ашиглан тааваар нь идээшлүүлнэ.
- Малыг тээвэрлэхдээ зориулалтын тусгайлан бэлтгэсэн тээврийн хэрэгсэл ашиглана.
- Малыг хаших, хариулах, тээвэрлэхдээ хүчтэй, хатуу зүйлээр цохих, ороолгох, чанга орилох зэргээр айлгаж, цочоож, тамлан зовоохгүй.
- Малыг хаших, уях, хөтлөх, ногтлох, хазаарлахдаа уламжлалт аргаар сур, дээс, хялгас ашиглах, гэмтэл учруулахгүй, айдас төрүүлэхгүй тавлаг байдлыг хангана.

Байгальд ээлтэй байх байдал:

- Дөрвөн улиралд нүүдэллэж байршсан газрын орчмын хогийг цэвэрлэж, байгаль орчныг бохирдуулахгүй, хог хаягдал үлдээхгүй байна.
- Өвөлжөөний хөрзөнг жил бүр авах ба түлшинд ашигладаг байна.
- Үхрийн баасыг цуглуулж хатаах ба буцааж түлшинд ашигладаг байна.
- Бог малын хорголыг хатааж бууц болгон ашигладаг байна.
- Ахуйн хогийг төвлөрсөн цэгт байршуулж, устгана.
- Малын гаралтай хаягдлыг дахин боловсруулж ашигладаг байна.

Нэмэлт мэдээлэл

Малын арчилгаа, маллагаа, хашаа, байрны талаар:

Малчид бэлчээрийн мал аж ахуйн уламжлалт аргаар монгол малаа адгуулан маллаж, арвин ашиг шим авах гол үндэс нь малаа байгаль, цаг уурт нь сайн дасгах, нутаг бэлчээрийг тохируулан сонгох, тарга хүч сайн авхуулах, хүйтэнд өлчиржүүлэн чийрэгжүүлэх, уяа сойлгыг тохируулах, хур таргатай онд оруулах зэргийг зохицуулж ирсэн уламжлалтай билээ.

Мал сүрэгт нутаг бэлчээрийг сонгон тохируулж таргалуулахдаа ургамлын хөгжлийн үе шат, идэмж, газар нутгийн байдал, бэлчээрийн ургамлын бүтэц бүрэлдэхүүн, өтгөн шингэн, өндөр нам, усны сайн муу, тэнгэр огторгуйн байдлыг харгалзан үздэг байжээ.

Мал нь тодорхой үе шатыг дамжин таргалж, сайн арчилгаа маллагааны нөхцөлд хур таргатай онд орж, ашиг шимж өгдөг зүй тогтолтой байдаг.

Манай өвөг дээдсийн урт хугацааны ажиглалт, уламжлан ирсэн туршлагаас үзэхэд таван хошуу мал нь үндсэн гурван үеийг дамжин таргалдаг байна. Тарга хүчийг ерөнхийд нь **усан, махан, өөхөн таргын үе** гэж нэрлэн ангилж болно. Үүнд:

Усан тарга: Төрөл бүрийн мал сүрэг өвөл, хаврын цагт алдсан ус, шингэнээ нөхөх гол зүйл нь шинэ ногооны шим бөгөөд түүний хүчээр малын биед шимт бодисууд бий болж чийг нэмэгдэн мал тэнхэрч, мах хөөж, малын биед усны солилцоо нэмэгдэх үйл явц мөн.

Махан тарга: Мал ногоонд бүрэн цадсаны дараа элгэнд шимт бодис хуримтлагдан уургийн солилцоо идэвхжиж, бүх шимт бодис ялангуяа уургийн бодис нэмэгдэн биед хэрэгцээт бодисын нөөц бий болгох, чийг багасгах, махлалт түргэсгэх, мах хөөж зузаарах, булчин томрох,

амьдын жин нэмэгдэх, махны гол бүрэлдэхүүн уургийн бодис нэлээд хэмжээгээр нэмэгдэхийг хэлнэ.

Өөхөн тарга: Цаг агаарын байдал сэрүүсэж, өвс хагдарч, бэлчээрийн маллагаатай мал сүрэг улирлын аясыг даган өвөлд бэлтгэх зохицлын дагуу шимт бодисыг биедээ хуримтлуулан нөөцлөх, өөхний хэмжээ эрс нэмэгдэх, уургийн солилцоо багасан тос, өөхний солилцоо идэвхжин сайжирч махны илчит чанар эрс нэмэгдэж тарга хүч чамбайрахыг өөхөн тарга гэнэ.

Тарга хүч авах хугацааг аваад үзвэл тухайн жилийн цаг агаарын байдал, ногооны ургацаас шалтгаалан эрт, орой ямар нэгэн хугацаанд тарга эхэлж, дуусаж байгаа боловч ерөнхийдөө ямар ч төрлийн мал дээр дөрөвдүгээр сарын дундаас усан тарга эхэлж зургаадугаар сарын сүүл хүртэл хүртэл үргэлжлэн, зургаадугаар сарын сүүлээс есдүгээр сарын эхээр махан тарга дуусаж, есдүгээр сарын дундаас өөхөн тарга эхлэн, зарим мал дээр арван нэгдүгээр сарын сүүл хүртэл үргэлжилдэг.

Дулаан хашаа, байр: Монголчууд дээр үеэс дунд идэш, дулаан хэвтэр гэж ярьдаг. Малыг эрүүл өсгөн үржүүлэхийн нэг үндэс нь дулаан хашаа, байраар хангах явдал мөн. Малчид малын тавлаг байдлыг хангахад юун түрүүнд өвөл хаврын улиралд малын төрөл, нас, хүйс, ашиг шимийн чиглэл, бүс нутгийн экологийн онцлог, малынхаа хэрэгцээ шаардлагыг хангасан өвөлжөө, хаваржааны зориулалтын хашаа, саравч, хороо, байртай байх шаардлагатай юм.

Малын тавлаг байдлыг хангах асуудал нь төрөл бүрийн малын хашаа байрны газрыг яаж сонгож авахаас эхлээд хашаа байрны хийц, хэмжээ, зориулалт, чанар, малын эрүүл ахуйн нөхцөлийг хэрхэн тохируулахаас ихээхэн хамаарна. Нөгөө талаас хашаа байр нь зөвхөн бэлчээрийн мал сүргийг хүйтний улиралд хамгаалах, тэжээллэг маллагааны газар болох төдийгүй малчдын удаан хугацаагаар суурьшин амьдардаг төв нь болдог тул малын эрүүл ахуйн нөхцөл, бэлчээр, усны хүрэлцээ, тэжээлийн нөөцийг харгалзаж наранд ээвэр, нөмөр дулаан, цас хунгарлахгүй, үеэр усны замаас зайдуу газрыг сонгож авах хэрэгтэй.

Бэлчээрээр малладаг монгол малын хувьд 12 дугаар сараас 5 дугаар сар хүртэл хашаа байранд байлгах шаардлагатай. Малын хашааг орон нутгийн материал ашиглан аль болох хямд төсөр, чанар сайтай баривал он удаан жил ашиглагдана. Ялангуяа хашааны барилгын суурь, хананд орон нутгийн элбэг материал болох чулууг өргөн ашиглахын хамт тоосго, блок цохиж барих бүрэн боломжтой. Байгаль орчин, ой модоо хамгаалахтай холбоотойгоор хашааны зайлшгүй бус хэсэгт мод хэрэглэхгүй байвал зохино. Малын хашаа, байрыг барихдаа зориулалт, технологи, зохистой талбай зэргийг сайн баримтлах нь зүйтэй юм.



Хашаа байрны эрүүл ахуй: Малын бодисын солилцоо, гэрэлтүүлэг, чийг, доторх халуун хүйтэн, орчны ариун цэвэр, нэг малд оногдох талбайн хэмжээ зэрэг үзүүлэлтүүд хамрагддаг. Эдгээр нь зохистой хэмжээнд байхгүй бол малын эрүүл мэнд, ашиг шимд сөргөөр нөлөөлөөд зогсохгүй, өвчлөл, үхэлд хүргэж болзошгүй.

Гадаад орчны хэмж –25 хэм болоход малын биеийн гадаргуугийн нэгж талбай бүхэнд 65–67 хэмийн дулааны эрчим хүч

болгох шаардлага гарна. Иймд малын биеийн дулаан алдалтыг ямар нэг хэмжээгээр багасгах нь тэр хэмжээний тэжээлийн үүргийг гүйцэтгэж байгаа хэрэг. Судалгаагаар үхрийн байрны тохиромжтой дулаан +10 хэм, бог малынх +12 хэм гэж тогтоосон байдаг ч манай бэлчээрийн малын байрны дулаан +5 хэм байхад хэвийн гэж үздэг. Иймд бэлчээрт байнга явж хөдөлж, нарны илч эрчим хүчийг сайн ашиглаж хүйтнийг тэсвэрлэх монгол малын энэ сайн чанарыг алдагдуулахгүй байх нь чухал юм.



Нэг малд оногдох хашаа байрны зохистой талбай

Байрлах мал	Нэг малд оногдох тайлбай, м2	
	Битүү байр	Саравчтай хашаа
Нарийн нарийвтар ноост эм хонь	1	0,5
Хутгийн эм хонь, ямаа	0,7	0,5
Эр сувай хонь, ямаа	–	0,3
Сайн үүлдрийн бух	6–6,5	–
Сайн үүлдрийн үнээ /уяатай нөхцөлд/	6,5–7	–
Сайн үүлдрийн үнээ /уяагүй нөхцөлд/	7–7,5	–
Тугал	1,5	–
Бяруу	2	–
Нутгийн үүлдрийн бух	–	4
Тугалтай эрлийз үнээ	3	–
Тугалтай монгол үнээ	–	2,5
Эр сувай үхэр	–	2

Зүй бус хорогдол: Том малын зүй бус хорогдолд өвчний (халдвартай, халдваргүй) хорогдол, гэнэтийн аюулын (цас зуд, үер ус, гал түймэр, аянга цахилгаан зэрэг) хорогдол, бусад шалтгааны (малын хариулга, арчилгаа маллагаатай холбогдон гарсан) хорогдлыг хамруулдаг. Малчин өрхийн зүй бусаар хорогдсон том малын эзлэх хувь хэмжээг оны эхний малын тоонд харьцуулан сүүлийн 3 жилийн дунджаар тооцоход **бод малд 4 хүртэл хувь, бог малд 6 хүртэл хувь** байх шалгуур үзүүлэлтийг тавьсан байна.

Өвс тэжээлийн хүрэлцээ хангамж: “Тарган мал тал бүрийн ашигтай, туранхай мал тал бүрийн яршигтай” хэмээн монголчууд зүйрлэн хэлж малынхаатэжээлийнхангамжидихээхэнанхаарч намар цагт хадлан тэжээлээ бэлтгэж өвөл хаврын

бэлтгэлээ хангадаг. Малчин хүн малын тавлаг байдлыг хангахын тулд малын ашиг шимийн хэрэгцээ, амьдралын шаардлагыг хангахуйц бэлчээр, тэжээлийн нөөцийг төлөвлөж хариулга маллагаа зохицуулах, хүрэлцэхүйц нэмэгдэл тэжээлийг бэлтгэх шаардлагатай. Ингэхдээ мал сүргийг жилд 300–оос дээш хоногийн хугацаанд байгалийн бэлчээрт бэлчээрлүүлнэ гэж тооцож өвөлжилт, хаваржилтад зориулж малд өгөх өвс, нэмэгдэл тэжээл бэлтгэж нөөцлөх ба энэ нь 90–ээс доошгүй хоногт хүрэлцэхүйц байх юм. Мөн бүс нутгийн онцлогт уялдуулж малд давс, хужир, зэрэг эрдэс тэжээл нөөцөлж тэжээх нь малын жингийн хорогдлыг тогтвортой байлгах, хадлан, тэжээлийн ургамал тариалалтад зөвхөн органик бордоог зааврын дагуу хэрэглэнэ. Малыг физиологийн норм, жорын дагуу тэжээх ба өлдөөхгүй цангаахгүй байх шаардлагатай юм.

Тэжээлийг гарал үүслээр нь ургамлын болон амьтны гаралтай, багсармал, хүнсний хаягдал, эрдэс тэжээл, биологийн идэвхт нэмэгдэл гэж ангилдаг. Ургамлын гаралтай тэжээлийг дотор нь хуурай буюу бүдүүн, чийглэг буюу шүүст тэжээл гэж хоёр бүлэгт хуваана.

Бүдүүн тэжээлд: Төрөл бүрийн өвс, сүрэл, лай, шилмүүс, мөчир зэрэг ордог.

Шүүст тэжээлд: Төрөл бүрийн ногоон ургамал, үндэс ба булцуу үртэн, дарш орно.

Манай орны малын бүдүүн тэжээлийн зонхилох хувийг өвс эзэлдэг. Байгалийн ногоон ургамлыг хадаж, удаан хугацаанд хадгалахад ялзарч муудахааргүй болтол нь хатааж хадгалсныг өвс гэнэ. Ингэж бэлтгэсэн /хадлан/ өвс нь 15–17 %-ийн чийгтэй байх ба навч, цэцэг эмзэг хэсгээ аль болохоор бага гээж ногоон өнгө, анхилуун үнэрээ сайн хадгалсан байх шаардлагатай. Өвсний найрлага, шимт чанар нь ургамлын бүрэлдэхүүн, хадах үеийн хөгжлийн үе шат, хадаж бэлтгэсэн арга, тухайн үеийн цаг агаарын онцлогоос хамааран янз бүр байдаг. Сайн чанарын өвсний найрлагад эрдэс бодис болон каротин их байхаас гадна Д,Е,К, В бүлгийн болон С амин дэм багагүй байдаг.



Малын усан хангамж: Нүүдэлч малчид хэзээнээс эхлэн усыг “чандмань эрдэнэ” гэж үзэн түүнийгээ ямагт цэвэр ариун байлгахыг эрмэлздэг. Малын уух усны чанар, хүрэлцээ хангамж нь малын тарга тэвээрэг, тавлаг байдалд мэдэгдэхүйц нөлөөлдөг тухай манай сайн малчдын олон санамж зөвлөгөө байдаг. Усны чанарын үзүүлэлт нь эрдэсжилт байдаг. Хэт их хужир давстай болон бохир ус уусан юм уу цэвэр усны хангамж дутагдсан мал янз бүрийн өвчин эмгэгтэй болох, давжаарах, ашиг шим буурах, амьдрах чадвар муудах зэрэг сөрөг үр дагавруудыг үүсгэдэг тул усан хангамжийн чанар хүрэлцээ, малын тавлаг байдалд

ихээхэн нөлөөлдөг. Жилийн 4 улиралд төрөл бүрийн малын ундны усны эх үүсвэр хүрэлцээ хангамж, ариун цэврийн шаардлага бүрэн хангасан байх шалгуур үзүүлэлтийг тогтоосон. Малыг өдөр тутам ханатал нь усалж байх нь бодисын солилцоог идэвхжүүлэх, биеийн илч, тарга тэвээргийг нэмэгдүүлж ашиг шимийн гарц сайжрах, улмаар малын зүй бус хорогдол буурах олон давуу талтай байдаг. Иймд хариуцлагатай малчид малын ундны усны эрүүл ахуйн шаардлага хангаж, усны эх үүсвэрийг хамгаалах, уст цэг, худаг, цөөрөм бий болгох сэргээн сайжруулах, засвар үйлчилгээ хийхэд тогтмол хөрөнгө оруулалт хийх шаардлагатай.

Мөн ил задгай усны эх булаггүй, худаг байхгүй соргог сайхан бэлчээрийг хаврын улиралд цөөн хоног боловч ашиглахын тулд цас, мөсийг нөөцлөн хадгалж малыг услах нь их үр дүнтэй байдаг. Цас, мөс нөөцлөх ажлыг 12 дугаар сараас эхэлж 2 дугаар сард багтаан дуусгана. Нөөцөлсөн цас, мөсийг ашиглан 3 дугаар сарын сүүлчээс 5 дугаар сарын дунд хүртэл 50 шахам хоног хайлуулан мал услах боломжтой. Нягтруулан дарж нөөцөлсөн 1 шоо метр цаснаас 250–300 литр ус, 1 тонн мөснөөс 1000 литр ус гаргаж авахаар тооцож нөөцөлнө.

Нөөцлөх зоорины хэмжээг ус уух малын тоо ба хаваржаанд нутаглах хоногийн тооноос хамаарч тодорхойлно. Цас, мөс нөөцлөн хадгалах зоорийг барих газрыг сонгохдоо дараах шаардлагад нийцүүлнэ.

- Хавар цас хамгийн сүүлд хайлдаг болох нь тогтоогдсон,
- Нарны гэрэл бага тусдаг буюу байнга сүүдэртэй байдаг,
- Цас их хунгарлаж хуримтлагддаг, эсвэл цас хунгарлуулах бололцоотой,
- Хаврын цасны үер дайрч урсдаггүй,
- Цуглуулсан цасыг трактор, машин, ердийн хөсгөөр зөөж авчрах бололцоотой,
- Хайлуулсан усыг хэрэгцээний хэрээр авах бололцоотой,
- Айлын хотноос хол биш зайтай,
- Ус хөрсөнд нэвчих, гадагшаа урсаж алдагдахааргүй, нар салхинд аль болох бага ууршихаар хамгаалагдсан байх,
- Усны ариун цэврийн нөхцөлийг хангасан байх,
- Цас, мөс нөөцөлсөн зооринд мал, амьтан орохооргүй хашаа, хамгаалалттай байх.



Мал туух, тээвэрлэх үеийн аюулгүй ажиллагаа:

- Малыг зориулалтын дэвсгэр, сүүдрэвчтэй, хамгаалалт бүхий тээврийн хэрэгслээр тээвэрлэх,
- Тээврийн хэрэгсэл дээр хэвтэх босох, өвс идэх зайтай байх,
- Алсын отор, туувар хийхэд урьдчилан төлөвлөсөн замаар явах,
- Малыг туух, хариулахдаа морь, ердийн хөсөг ашиглан хариулах,
- Малыг туух, барих тавих, хариулах үедээ мотоцикл машин техникээр хөөх, тээвэрлэж байгаа хашлаганаас уяж бэхлэх, шил дарж ачих, хатгуур хэрэглэхийг хориглоно.



Байгальд ээлтэй мал аж ахуйн үйлдвэрлэл:

- Малчин өрх орчны болон малын хашаа хорооны хог хаягдалыг тухай бүр цэвэрлэж хогийн цэгт цуглуулан устгах,
- Цогтой үнс, нурамыг тусгай зориулалтын тагтай саванд хийх, ил задгай хог шатаахыг хориглох, түймрээс сэргийлэх,
- Үхэр, тэмээний баасыг цуглуулан хатааж түлшинд хэрэглэх, бог малын хөлдүү хорголыг хамж хөх бууц бэлтгэх.
- Түлшиндээ малын аргал, хоргол, хөрсөн хэрэглэх, бут, мод загийг түлшинд хэрэглэхээс зайлсхийх,
- Мал аж ахуйгаас гарч буй хаягдалыг дахин боловсруулан бордоо болгон хэрэглэх гэх мэт.



2.2.3. Малын эрүүл мэндэд тавигдах шаардлага

1. Малын гоц халдварт болон зооноз өвчингүй, тайван байдал хангагдсан, эсхүл эрсдэл бүхий халдварт өвчнөөс хамгаалах дархлаа тогтсон мал сүрэгтэй байх.

- Тухайн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа Мал эмнэлгийн байгууллагатай жил бүр гэрээ байгуулан хамтран ажиллаж, мал сүргээ малын эмчийн байнгын хяналтад байлгана.
- Бүс, нутгийн хэмжээнд, эсхүл тухайн аж ахуйн хэмжээнд нэр бүхий гоц халдварт болон зооноз өвчингүй статусыг мал эмнэлгийн байгууллагаас баталгаажуулан гэрчилгээ олгосон бол холбогдох зааврын дагуу жил бүр шинжилгээ хийлгэж тухайн статусыг тогтвортой хадгалж байгаагаа нотолно.
- Хашаа, байрны ойр орчимд болон ашиглаж байгаа бэлчээрт үхсэн мал, амьтны хүүр, сэг зэгийг цуглуулж, устгахын зэрэгцээгээр гэрээт малын эмчээр халдваргүйтгэл хийлгэнэ.
- Мал эмнэлгийн байгууллагаас хэрэгжүүлж байгаа төлөвлөгөөт болон яаралтай дархлаажуулалтын товлот хугацаанд мал сүргээ ойр байлгаж, тухайн өвчинд мэдрэмтгий малыг бүрэн хамруулна.
- Мал сүрэгтээ өдөр тутмын хяналт тавих бөгөөд малд өвчний шинж тэмдэг илэрснээс хойш 12 цагийн дотор сумын мал эмнэлийн байгууллагад мэдэгдэнэ.

2. Малын шилжилт хөдөлгөөнийг хянах, биоаюулгүй байдлын анхан шатны арга хэмжээ хэрэгжүүлэх замаар тухайн сүрэгт гаднаас халдвар дамжих эрсдэлийг бууруулсан байх.

- Мал маллах, түүнийг ашиглах, эдлэх, тээвэрлэх үйл ажиллагааг хэрэгжүүлэхдээ мал, амьтны эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагаас баталсан “Хашаа, байр, тоног төхөөрөмж, тусгай зориулалтын тээврийн хэрэгслийн эрүүл ахуй, ариун цэврийн нийтлэг заавар”-ыг дагаж мөрдөнө.
- Гаднаас мал худалдан авахдаа түүний эрүүл мэндийн байдлыг онцгой анхаарах бөгөөд Мал эмнэлгийн гэрчилгээтэй тохиолдолд худалдан авна.
- Гэрээт мал эмнэлгийн байгууллагад дуудлага өгч мал тээвэрлэн ирж байгаа тээврийн хэрэгсэлд халдваргүйтгэл хийлгэнэ.
- Гаднаас худалдан авч байгаа болон сумын нутаг дэвсгэрээс гадна зохион байгуулагдсан арга хэмжээнд оролцуулаад буцаан авчирч байгаа малыг гэрээт мал эмнэлгийн байгууллагаас зөвлөсний дагуу хорио цээрийн хяналтад байлгасны дараа сүрэгт нийлүүлнэ.
- Саахалт айл болон хөрш фермийн халдварт өвчний эрсдэлийн талаар үнэлгээ хийлгэж, халдвараас хамгаалах үйл ажиллагааг хамтран хэрэгжүүлнэ.
- Зэрлэг амьтдаас байгалийн голомтот халдварт өвчин халдварлах эрсдэлтэй бэлчээрт малаа хариулгагүй бэлчээхээс зайлсхийнэ.
- Халдварт өвчин тараах эрсдэл бүхий зэрлэг амьтад хашаа, хороонд нэвтрэхээс хамгаалсан байна.
- Халдварт өвчин дамжуулах эрсдэлтэй шавж, мэрэгчидтэй тэмцэх арга хэмжээг эрх бүхий байгууллагатай хамтран хэрэгжүүлнэ.
- Цэвэр тоног хэрэгсэл, багаж төхөөрөмж ашиглахыг чухалчлан үзэх ба бусдын хэрэглэж байсан тоног хэрэгсэл, багаж төхөөрөмжид халдваргүйтгэл хийлгэсний дараа ашиглана.

3. Малын өвчнийг эрт илрүүлэх, шуурхай хариу арга хэмжээ хэрэгжүүлэх замаар тархалтыг богино хугацаанд хязгаарлах, малын эрүүл мэндийн түүхийг мөшгөх нөхцөлийг бүрдүүлсэн байх.

- Бүх малыг ялган тэмдэглээгүй тохиолдолд халдварт өвчний тандалт шинжилгээнд сонгогдсон болон антибиотикийн эмчилгээ хийсэн малыг нэг бүрчлэн ялган тэмдэглэнэ.
- Улирал тутамд нэгээс доошгүй удаа малын эмч дуудаж мал сүрэгтээ эмнэл зүйн үзлэг хийлгэнэ.
- Халдварт өвчний сэжиг илэрсэн малд лабораторийн шинжилгээ хийх, өвчтэй малд эмчилгээ хийх хугацаанд тэдгээрийг сүргээс ялган тусгаарлах боломжийг бүрдүүлнэ.
- Эрсдэл бүхий шимэгчтэх өвчнөөс эрүүлжүүлэх нэгдсэн арга хэмжээний товлот хугацаанд мал сүргээ ойр байлгаж, тухайн өвчинд мэдрэмтгий малыг бүрэн хамруулна.
- Өвчилсөн, бэртэж гэмтсэн малд зайлшгүй шаардлагаар анхны тусламж үзүүлсэн иргэн тухайн үед хэрэглэсэн эм, бэлдмэлийн нэр, хүчинтэй хугацаа, тун хэмжээний талаарх мэдээллийг малын эрүүл мэндийн дэвтэрт тэмдэглэнэ.
- Өвчилсөн малын эмчилгээний талаарх тэмдэглэлийн хуулбарыг малын эмчээс авч малын эрүүл мэндийн дэвтэрт хавсаргана.

4. Малын эм болон төрөл бүрийн химийн бэлдмэлийн хэрэглээний зохистой дадлыг нэвтрүүлэх замаар зөвшөөрөгдөх дээд хэмжээнээс хэтэрсэн эмийн үлдэгдэл агуулаагүй, баталгаатай бүтээгдэхүүнийг зах зээлд нийлүүлдэг байх.

- Зөвшөөрөгдсөн химийн бэлдмэлийг зөвхөн гэрээт мал эмнэлгийн байгууллагаар дамжуулан авч ашиглана.
- Химийн бэлдмэлийг хэрэглэхдээ түүнийг хэрэглэх заавар, тун хэмжээ, зохистой хугацааг хатуу мөрдөнө.
- Жоргүй олгох эмийг хэрэглэхдээ гэрээт малын эмчээс заавар, зөвлөмж авсан байна.
- Эмчилгээ, үйлчилгээнд жороор олгох эм хэрэглэх бол түүнийг зөвхөн малын эмч болон эрх бүхий этгээдээр хийлгэнэ.
- Дархлаажуулалт, угаалга, туулга, боловсруулалт зэрэг нэгдсэн арга хэмжээ болон эмийн эмчилгээний дараа хүлээх хугацааг үйлчилгээ үзүүлсэн малын эмч тогтоох бөгөөд уг хугацаа дуусаагүй үед малын мах, сүүг зах зээлд нийлүүлэхээс татгалзана.

Малчин гэрээт малын эмчийн зөвлөмж зааварчилгаагүйгээр эм, химийн бэлдмэл худалдан авах, зориулалтын бус нөхцөлд хадгалах, малын эмчилгээнд дур мэдэн хэрэглэхээс зайлсхийнэ

2.2.4. Малын нөхөн үйлдвэрлэл, үржүүлэг селекци–д тавих үндсэн шаардлага.

Бүртгэл хөтлөлт, төлөвлөлт

- Мал сүрэгт 4 төрлийн бүртгэл хөтлөх; /цөм, үржлийн, хэрэгцээний, мал төллөлт/
- Үржлийн малд хянан баталгаажуулалт хийлгэсэн байна (хээлтүүлэгч $90 \leq \%$, хээлтэгч $80 \leq \%$ –д үржлийн гэрчилгээ авна);
- Сумын Хөдөө аж ахуйн тасгийн бүртгэл, мэдээллийн нэгдсэн санд мал сүргийг бүртгүүлэх;
- Малын борлуулалт, шилжилт хөдөлгөөний талаар мэргэжлийн байгууллагад мэдээлдэг байх;

Малын ашиг шим, бүтээмж:

- Нэг малаас авч буй ашиг шимийн дундаж гарц ноос $1200 \leq \text{гр}$, ноолуур $270 \leq \text{гр}$ шаардлагыг хангах;
- Малын гаралтай түүхий эд бүтээгдэхүүнд чанарын үнэлгээ хийлгэж байх (ноосонд урт, ноолуурт микрон, сүүнд тослог, арьс ширэнд ашигтай талбай);
- Малын намрын амьдын жин дараах шаардлагыг хангах
- (4 настай адуу $380 \leq \text{кг}$, үхэр $330 \leq \text{кг}$, сарлаг $280 \leq \text{кг}$, тэмээ $440 \leq \text{кг}$, 3 настай хонь $50 \leq \text{кг}$, ямаа $45 \leq \text{кг}$);
- Малын махны гулуузны жин дараах шаардлагыг хангах (2 настай бод $120 \leq \text{кг}$, бог $18 \leq \text{кг}$);
- Малаас авч байгаа ашиг шимд эерэг өөрчлөлт гарч байгаа эсэх;

Малын үржүүлэг, селекц:

- Мал сүргийн үүлдэрлэг байдал зөвшөөрөгдсөн бүс нутаг, төрөл зүйлд нийцсэн байх;
- Хээлтүүлэгчийн хүрэлцээг тогтоосон нормд байхаар зохион байгуулах;

Малын нөхөн үйлдвэрлэл:

- Эдийн засгийн эргэлтэд оруулсан эр сувай малын оны эхний малд эзлэх хувь бодын сүрэгт 15 ба түүнээс богийн сүрэгт 35 ба түүнээс дээш хувь;
- Тухайн жилийн төл бойжилтын хувь бүс нутгийн болон цаг уурын онцлогоос хамаарч хэлбэлзэж болох ба нийтлэг дараах шаардлагыг хангасан байх (адуун сүрэгт $95 \leq$, үхэр сүрэгт $96 \leq$, тэмээн сүрэгт $97 \leq$, хонин сүрэгт $95 \leq$, ямаан сүрэгт $93 \leq$ хувь);

Бэлчээрийн мал аж ахуйн онцлог нөхцөл байдлыг тухайн сум, аймгийн экологийн ямар бүсэд хамаарч байгаа, энэ бүс нутгийн уур амьсгал, нутаг бэлчээрт хамгийн сайн дасан зохицсон, эдийн засгийн ашиг орлого илүүтэй, байгаль орчиндоо сөрөг нөлөөгүй, мал сүрэг, бэлчээр хоёр нь харилцан ашигтай байх нөхцлийг бүрдүүлэх менежментийг хэрэгжүүлэх эдийн засгийн хөшүүргийг олон талаас нь сайтар судлан, зөв тогтоох нь Сумдын ИТХ-ын хамгийн чухал үүрэг, хариуцлага оршиж байгаа болно.

1. Сум, баг, БАХ-ийнхаа нутаг бэлчээрийн онцлогтой уялдуулан сумынхаа таван төрлийн малаа ач холбогдолоор нь (тэмээ–1, ямаа–2, хонь–3, үхэр–4, адуу–5, гэм мэтээр...) эрэмбэлж, нийт малд, төрөл бүрийн малын эзлэх хувийн жинг хамгийн зохистой байхаар тооцож, баг бүрийн ИНХ-аар болон сумын ИТХ-аар хэлэлцүүлэн баталгаажуулсан байх,
2. Бэлчээрт байх зохистой хэмжээний хонин толгойд шилжүүлсэн малын тоог таван төрлийн малын бодит тоо болгохдоо (тэмээ–3.5%, ямаа–23.5%, хонь–55.0, үхэр–8.0%, адуу–10.0% гэм мэтээр...) өөрсдийн онцлогт тохируулан зөв тооцох,
3. Сумынхаа экологийн бүс нутгийн онцлогтой уялдуулан зонхилох төрлийн малын уламжлалт зохистой байршил болон зорилтод зах зээлийн эрэлт хэрэгцээг харгалзан тухайн төрлийн малаа ашиг шимийн ямар чиглэлээр үржүүлэх зорилтоо зөв тодорхойлсон байх,
4. Энэ зорилтыг хэрэгжүүлэхийн тулд мал сүргийг “тооноос – чанарт” шилжүүлж, эдийн засгийн эргэлтийг эрчимжүүлэхийн тулд ямар үүлдэр, омгийн малаар сайжруулахыг сумынхаа хэмжээнд шийдвэрлэсэн байх, (тэмээг–Галбын говийн улаан үүлдрээр, ямааг– Залаажинст–Эдрэн үүлдрээр, хонийг– Говь–Алтай үүлдрээр, үхрийг – КЦТ үүлдрээр, адууг – Тэс омгоор гэм мэтээр...)
5. Эдгээр тооцоог нэгдсэн журмаар нийтэд өргөн хэрэглэж байгаа “Бэлчээрийн мал сүргийн эргэлтийн тооцоолол боловсруулах программ”-ыг ашиглан үнэн зөв хийсэн байх,
6. “Малын генетик нөөцийн тухай хууль”-ийн дагуу малын чанар сайжруулах ажил, үйлчилгээ үзүүлэх үүрэг бүхий Мал үржүүлэг, технологийн ажил, үйлчилгээний нэгжид албан ёсоор төвлөрүүлсэн, стандартын шаардлага хангасан, тухайн суманд сайжруулагчаар ашиглахыг зөвшөөрсөн үүлдэр, омгийн хээлтүүлэгч малыг албан татвараас чөлөөлөх зарчим баримтлах, (Малын чанар сайжруулах үндсэн зэвсэг бол – сайн чанарын хээлтүүлэгч учир бүх нийтийн эрх ашгийн төлөө үйлчилгээ үзүүлэх гэдэг зарчим)
7. Эдгээр үүлдэр, омгийн сүрэг сэлбэх өсвөр хээлтүүлэгчийг бойжуулах зориулалтаар эрх бүхий мэргэжлийн байгууллагаас шилэн сонгож, бүрдүүлсэн цөм сүргийн эх малыг (эм хонь, эм ямаа, үнээ ... гэх мэт) Сумын ХАА-н тасгийн цахим бүртгэл дэхь мэдээлэлийг үндэслэн уг албан татвараас чөлөөлөх зарчим баримтлах,
8. ХХААХҮ-ийн сайдын 2020 оны А/15 дугаар тушаалаар баталсан “Таван төрлийн малын үржлийн ажлын стратеги”-ийн дагуу сум, аймаг бүр ойрын болон дунд хугацааны стратеги төлөвлөгөөг боловсруулан хэрэгжүүлэх,
9. “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-ын дагуу сум, дүүргийн ОНХС-д төвлөрөх Малын тоо толгойн албан татварын орлогын хөрөнгөөр малын чанарыг сайжруулах чиг үүргийн хүрээнд хөрөнгө оруулалт хөтөлбөр, төсөл, арга хэмжээг санхүүжүүлэхдээ:

Мал үржүүлэг, технологийн ажил, үйлчилгээний нэгжийн үйл ажиллагааг дэмжин чадвахжуулахад,

Стандартын шаардлага хангасан, суманд сайжруулагчаар ашиглахыг зөвшөөрсөн, эрүүл

хээлтүүлэгчийн хангамж, чанарыг сайжруулах зорилгоор өсвөр хээлтүүлэгч худалдан авах, арчилж маллах, тэжээх материаллаг баазыг бэхжүүлэх чиглэлд нэн тэргүүнд зарцуулж, сумынхаа малыг чанаржуулах нөхцлийг бүрдүүлэх боломжтой гэж зөвлөж байна.

2.2.5. Малын гаралтай түүхий эд бэлтгэлд тавих үндсэн шаардлага.

1. Бүртгэл хөтлөлт, төлөвлөлт

- Бэлтгэсэн түүхий эд бүтээгдэхүүний бүртгэл хөтөлнө.
- Борлуулсан түүхий эд, бүтээгдэхүүний бүртгэл хөтөлнө.
- Түүхий эдийн гарал үүслийн түүхийг мөшгөх нөхцөлийг бүрдүүлсэн байна.
- Түүхий эд бүтээгдэхүүний чанарыг сайжруулах талаарх төлөвлөгөө боловсруулан мөрдөж ажиллана.
- Түүхий эд бэлтгэх үед малд гэмтэл бэртэл үүссэн тохиолдолд бүртгэл хөтлөн, дариу эмчлэх, өвдөлт намдаах арга хэмжээ авна.
- Түүхий эдэд чанарын хамгаалалт хийх зориулалтын байр байгууламжтай байна.



2. Ноос, ноолуур бэлтгэл

- Ноос, ноолуурыг дараах стандартын шаардлагад нийцүүлэн бэлтгэнэ.
- MNS 6375:2013 Ноос, ноолуур.Түүхий эд бэлтгэл. Ямааны ноолуур. Техникийн шаардлага
- Ноолуурыг бэлтгэхдээ цагаан, цагаан цайвар, цайвар, бараан гэж 4 өнгөөр, дээд, I, II, III гэж чанараар мөн борлон, нас гүйцсэн гэх зэргээр насаар нь ангилж бэлтгэх
- Ноолуурыг бэлтгэхдээ орчин тойрны хог хаягдлыг цэвэрлэн, шаардлага хангасан дэвсгэр ашиглаж, хогт хольц үүссэн бол цэвэрлэдэг байх
- Сэрмэн хайчилж, зориулалтын самаар самнадаг эсэх
- Ноолуурыг савлахдаа химийн мяндас хөвөрч наалдахгүй тааран болон зориулалтын шуудай ашигладаг эсэх

Сав, баглаа боодол:

Стандартын дагуу чанартай ноолуур бэлтгэхийн тулд ноолуурыг нас, хүйс, зэргээр нь ангилан ялгаж тус тусад нь зоориулалтын шуудайнд савлана. Ноолуур савлахад ус, чийг нэвтрүүлэхгүй даавуун болон тааран шуудайг сонгох нь хамгийн тохиромжтой. Ингэснээр ноолуур чанараа алдах, гологдол үүсэхээс сэргийлнэ.

Хаягжуулалт: Ноолуурын зэрэг, өнгө, чанар, нас, хүйс, бэлтгэгчийн талаарх мэдээлэлийг бичиж хаялана. /Аймаг сум, малчны нэр, хаяг г.мэт/

MNS 0036:2015 Ноос, ноолуур. Түүхий эд бэлтгэл. Тэмээний ноос. Техникийн шаардлага

- Тэмээний эх биеийн ноосыг чанараар нь ангилдаг байх.
- Тэмээний эх биеийн ноосыг өнгөөр нь ангилдаг байх.
- Тэмээний эх биеийн ноосыг гадаад байдал бохирдлоор нь ангилдаг байх.
- Тэмээний зогдор ноосыг гадаад байдал бохирдлоор нь ангилдаг байх.

MNS 0033–2007 Ноос, ноолуур.Түүхий эд бэлтгэл. Хонины ноос. Техникийн шаардлага

- Хонины ноосыг бэлтгэхдээ өнгөөр нь цагаан, өнгийн гэж 2 ангилж бэлтгэнэ.
- Хонины ноосыг бэлтгэхдээ чанараар нь нэгдүгээр анги, хоёрдугаар анги, гуравдугаар анги гэж ангилж бэлтгэнэ.
- Хонийг ноослоход осгож, бээрэхгүй байх хугацааг сонгон тохирсон хугацаанд нь ноослодог.
- Хамгийн тохиромжтой хугацаа 5 сарын сүүл, 6 сарын эх байдаг.
- Тосон будаг, замын хараар тэмдэглэсэн ноосыг үргэлж ноосноос салгадаж хаяна.
- Ноосыг чийг, тоос нэвтрэхгүй, зориулалтын нар салхинаас хамгаалсан тааран уутанд агуу зөв савлах нь тохиромжтой.
- Шарласан, бутархай дайх ноосыг тусад нь савлана.

MNS 6377:2013 Ноос, ноолуур. Түүхий эд бэлтгэл. Сарлагийн хөөвөр. Техникийн шаардлага

- Сарлагийн хөөврийг бэлтгэхдээ самнаж эсвэл хяргаж бэлтгэнэ. Самнасан ноос нь илүү зөөлөн, ноолуурлаг, хялгас бага байдаг тул хяргаж бэлтгэх нь илүү тохиромжтой.
- Сарлагийн хөөврийг бараан бор, бор, цайвар бор, саарал гэсэн 4 өнгөөр, бяруу болон нас гүйцсэн гэж ангилан ялгаж бэлтгэж байх.



- Сарлагийн хөөврийн стандартын дагуу бараан, бор, цайвар бор, хөх гэж 4 өнгөөр, бярууны болон нас гүйцсэн гэж насаар ялгаж бэлтгэдэг.
- Сарлагийн хөөврийг бэлтгэн борлуулахдаа хог, хаягдал, хялгас дайхыг нь ялгаж байх. Сарлагийн хөөврийг хадгалж тээвэрлэхдээ зориулалтын, чийг тоос орохгүй уутанд савлаж хадгалж, тээвэрлэдэг байх

Ноолуурын чанар гарцыг нэмэгдүүлээхийн тулд анхаарах зүйл нь ямаа самнах хугацааг зөв тааруулах нь чухал байдаг. Эхний ээлжинд тэвээрэг сайтай, ноолуур нь сайн хөөрсөн эр, сувайг дараа нь хээлтэй ямааг ишиглэснээс хойш 7–14 хоногийн дараа, хамгийн сүүлд борлон, цариг муутай орсон ямаа, ухна гэсэн дарааллаар араа, хамгийн сүүлд борлон, цариг муутай орсон ямаа, ухна гэсэн дарааллаар самнахаар ажлаа төлөвлөвөл зохино.

MNS 0070:2007 Ноос, ноолуур. Түүхий эд бэлтгэл. Хөөвөр. Техникийн шаардлага

- Малын ноос ноолуурыг технологийн хугацаанд бэлтгэнэ.
- Малыг барих, уяж бэхлэх, ноослохдоо малыг айлган цочоох, айдаст автуулах, ширүүн хандахыг цээрлэнэ.
- Мал бүрийн зан ааш, галбир бүтцийн онцлогт тохируулан мал барих, бэхлэх (хүзүү, толгой, хөлийн бэхэлгээ) хэрэгслийг зөв сонгоно.
- Малын уяа бэхэлгээг хийхдээ боохгүй, мултрахааргүй бөхөлж, хөвөрхий тооно туших аргыг хэрэглэнэ.
- Мал ноослох багаж хэрэгсэл сам, хайч, хүлэх бэхлэх дээс зэрэг нь малд бэртэл гэмтэл үүсгэхгүй стандартын шаардлага хангасан байна.
- Мал ноослохдоо осгох бээрэх, наранд цохиулахаас сэргийлэн сүүдрэвч ашиглах, нэмнэх арга хэмжээг авна.

Сам:

1. Даахины сам (хол шүдтэй) шүд хоорондын зай 6–7 мм
2. Ноолуурын сам (ойр шүдтэй) шүд хоорондын зай 4–5 мм
3. Шүүр сам (шигүү шүдтэй) шүд хоорондын зай 2–3 мм

Ямааг самнахдаа стандартын шаардлага хангасан самыг хэрэглэх нь тухайн малын биед элдэв гэмтэл учруулдаггүй, самнагчийн хөдөлмөрийн бүтээмж нэмэгдэх зэрэг эерэг нөлөөтэй



- ~ Самны шүдний үзүүр нь малын арьсанд гэмтэл учруулахгүйгээр ирлэгдсэн байх,
- ~ Малыг биеийн үсэн бүрхүүлээс ноолуурлаг хэсгийг нь бүрэн самнаж авах чадвартай байх,
- ~ Малчны гараас ирэх ачааллыг найдвартай даахаар бат бэх байх,
- ~ Самны шүдийг гантай төмөр утсаар хийсэн байх ... зэрэг малчдаас гаргасан шаардлага хүсэлтүүдийг мөн тусгасан болно.

МОНГОЛ УЛСЫН СТАНДАРТ

Ангиллын код: 77.140.99

Ноос, ноолуурын сам. Техникийн шаардлага	MNS: 1012-2016
Wool and cashmere comb. Technical requirement.	MNS: 1012-2015-оронд

Стандартчиллын Үндэсний Зөвлөлийн 2016 оны ...дугаар сарын ...-ны өдрийн ... р тогтоолоор батлав.

Энэхүү стандарт нь улсын бүртгэлд бүртгэгдсэн өдрөөс хойш хүчинтэй.

1. Хамрах хүрээ

Энэхүү стандарт нь ноос, ноолуурын сам үйлдвэрлэх, шалгах, хүлээн авах, тээвэрлэх хадгалахад хамаарна.

2. Норматив ишлэл

Энэхүү стандартыг боловсруулахад дараах норматив баримт бичгийг ашигласан бөгөөд эдгээр стандартад өөрчлөлт орсон тохиолдолд хамгийн сүүлчийн албан ёсны хэвлэлийг иш татаж хэрэглэнэ. Үүнд:

- MNS 1-1 2006, Монгол улсын үндэсний стандартчиллын тогтолцоо 1-р хэсэг Техникийн ажлын журам.
- MNS 1-2 2006, Монгол улсын үндэсний стандартчиллын тогтолцоо 2-р хэсэг Стандарт боловсруулах арга зүй

3. Нэр томьёо, тодорхойлолт

3.1 Даахь ноосны сам – стандартад заасан хэмжээгээр хийсэн, даахь ноосыг задлах зориулалттай самыг;

3.2 Ноолуурын болон эм ноосны сам – стандартад заасан хэмжээгээр хийсэн, биеийн даахирсан ноосыг задалсны дараагаар ноолуур, эм ноосыг самнаж авах зориулалттай самыг;

3.3 Самны шүд хоорондын зай – зэргэлдээ хоёр шүдний тэнхлэгийн хоорондын зайг;

MNS 0070:2007 Ноос, ноолуур. Түүхий эд бэлтгэл. Хөөвөр. Техникийн шаардлага

- Малын ноос ноолуурыг технологийн хугацаанд бэлтгэнэ.
- Малыг барих, уяж бэхлэх, ноослохдоо малыг айлган цочоох, айдаст автуулах, ширүүн хандахыг цээрлэнэ.
- Мал бүрийн зан ааш, галбир бүтцийн онцлогт тохируулан мал барих, бэхлэх (хүзүү, толгой, хөлийн бэхэлгээ) хэрэгслийг зөв сонгоно.
- Малын уяа бэхэлгээг хийхдээ боохгүй, мултрахааргүй бөхөлж, хөвөрхий тооно туших аргыг хэрэглэнэ.
- Мал ноослох багаж хэрэгсэл сам, хайч, хүлэх бэхлэх дээс зэрэг нь малд бэртэл гэмтэл үүсгэхгүй стандартын шаардлага хангасан байна.
- Мал ноослохдоо осгох бээрэх, наранд цохиулахаас сэргийлэн сүүдрэвч ашиглах, нэмнэх арга хэмжээг авна.

3. Арьс шир бэлтгэл

- Арьс ширийг MNS 0060:2013 Түүхий эд бэлтгэл, Боловсруулаагүй арьс шир Техникийн шаардлага стандартын шаардлагад нийцүүлэн бэлтгэнэ.
- Үхэр, адуу, тэмээний шир, хонь ямааны арьсыг стандартын дагуу зөв өвчиж бэлтгэдэг байх.

Анхаарах зүйл:

- Үхэр адууны шир, хонь ямааны арьсыг өөхийн цагаан судлыг дагуулан тууш байдлаар, шилбэний үе хүртэл яралт хийж эрүү, шанааны арьсны хамт өвчиж бэлтгэнэ.
- Арьс ширийг өвчихдөө шар мах, өөх дагуулахгүй, урах, эсгэж, огтлохгүй, нүх гаргахгүй, эвэр, туурай, шийр, чих, уруул, чих, засаа, дэл, сүүл зэргийг арьсанд үлдээхгүй салгасан байх
- Үхэр адууны сүүлний арьсыг угаас 8 см хүртэл урттай үлдээж тайрна.
- Тэмээний ширийг нурууны дагуу ярж, хүзүүний арьсны хамт, эсвэл өөхийн цагаан судал, бөхний дагуу ярж, хүзүүний ширийг нэг талд үргэлж өвчиж бэлтгэнэ. Ноосыг чийг, тоос нэвтрэхгүй, зориулалтын нар салхинаас хамгаалсан тааран уутанд агуу зөв савлах нь тохиромжтой.
- Малын арьс ширийг өвчихдөө шар мах, өөх дагуулахгүй, урах, эсгэж, огтлохгүй, нүх гаргахгүй, эвэр, туурай, шийр, чих, уруул, чих, засаа, дэл, сүүл зэргийг арьсанд үлдээхгүй салгасан байна..
- Арьс, ширийг өвчсөний дөрөө хоёр цагийн дотор халим, шар мах, цус, өвс хог зэргийг цэвэрлэсэн байна.
- MNS 5094:2001 Чанарын хамгаалалт хийх, баглах, тээвэрлэх, хадгалах стандартын дагуу анхан шатны тордолт хийсэн байна. Арьс ширэн түүхий эдэд хийх чанарын хамгаалалтыг зориулалтын байгууламжид мэргэшсэн ажилтан гүйцэтгэнэ.
- Арьс ширэн түүхий эдийн чанарыг муутгах үйлдлээс зайлсхийж, ялангуяа нэхийг өлөн гэдэстэй хамт боож ялзрал үүсгэхгүй байна.

Анхаарах зүйл:

- Нэхийг өлөн гэдэстэй хамт боож боодоггүй байх
- Арьс ширэн түүхий эдийг тээвэрлэхдээ гарал үүсэл, чанарын хамгаалалтын арга, тоо ширхэг, жин хэмжээ, агуулахын дугаар, ангилан ялгагчын дугаар, код, огноо зэргийг тусгасан баримт бичгийг дагуулна.
- Мал эмнэлэг болон ариун цэвэр, биологийн ариутгал хийгдсэн температур, орчин нөхцөлд тохирсон агуулахад хадгална.
- Давсалсан ба хөргөсөн арьс ширийг тээвэрлэхдээ тээврийн хэрэгслэлийн тэвшинд битүү давс цацаж, түүний даацын хэмжээгээр дэлгэмэл байдлаар ачиж, хөлдүү арьс, ширийг зориулалтын тээврийн хэрэгсэлээр тээвэрлэнэ.

4. Сүү бэлтгэл

Сүүг дараах стандартын шаардлагад нийцүүлэн бэлтгэнэ.

- MNS 4228:2011 Малын түүхий сүү. Техникийн шаардлага
- MNS 4229:2011 Эсэг цагаан идээ Техникийн шаардлага,
- MNS 4230:2005 Уурагт цагаан идээ, Техникийн шаардлага,
- MNS 4528:2011 Тослог цагаан идээ, Техникийн шаардлага

- Түүхий сүүг бэлтгэн нийлүүлэхдээ мал эмнэлэгэрүүл ахуй, ариун цэврийн шаардлагад нийцүүлэн анхан шатны боловсруулалт хийгдсэн байна.
- Халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх вакцин тарилга, угаалгад тухайн мал хамрагдсанаас хойш 7–28 хоногийн дараа сүүг бэлтгэн нийлүүлнэ.
- Дэлэнгийн үрэвсэл, сүрьеэ, бруцеллёз, зэрэг хүнд дамжин халдварлах болон малын гоц халдварт өвчнөөс ангид, эрүүл, тайван бүсээс бэлтгэсэн, гарал үүсэл нь баталгаажсан малын түүхий сүүг үйлдвэрт нийлүүлнэ.
- Мал төллөхөөс өмнөх болон төллөснөөс хойшхи 7 хоногын хугацаанд болон малын гоц халдварт өвчний хорио цээрийн дэглэм тогтоосон бүс нутгаас түүхий сүүг үйлдвэрт нийлүүлэхийг хориглоно.

- Саальд ашиглаж буй тоног хэрэгсэл, арга технологи нь малд гэмтэл бэртэл учруулах, айдас дарамт үүсгэхээргүй, халдвар дамжуулахгүй эрүүл ахуйн нөхцөлийг бүрдүүлсэн байна.
- Өсвөр малын хамарт шор, дөр, амгайвч зэргийг хэрэглэхгүй байна.

5. Мал мах бэлтгэл

- Малын махыг стандартын дагуу бэлтгэдэг эсэх
 - “MNS 1111:2007 Үхэр, өсвөр үхэр, адууны өрөөл мах, хонь, ямаа, хурганы гулууз мах. Техникийн ерөнхий шаардлага”,
 - “MNS 2457:2009 Мах, махан бүтээгдэхүүн. Хонь, ямааны хэсэглэж, ангилсан мах. Ерөнхий шаардлага” стандартуудыг дагаж мөрдөнө.
- Малын тээвэрлэхдээ хэт олноор зориулалтын бус тээврийн хэрэгслээр тээвэрлэхийг хориглоно.
- Төхөөрөх зориулалтаар тээвэрлэж буй малыг амраан ус, тэжээлээр хангана. Малыг айдас дарамтад оруулахгүйгээр төхөөрнө.

2.3 Сургалтын арга зүй

2.3.1 Дөхүүлэх асуултын арга:

Энэ сургалт иргэдийн амьдралын мэдлэг ур чадвар дээр тулгуурлаж явагдах тул дөхүүлэх асуултын арга ач холбогдолтой. Асуултууд нь суралцахуйн чухал үр дүнтэй холбогддог ба сургалтын агуулгыг цааш үргэлжлүүлэхээс өмнө эгзэгтэй үед хэрэглэнэ. Оролцогчид биеэ барьсан идэвхгүй үед болон хариултын олон хувилбарууд гарч ирэхгүй байгаа нөхцөл байдалд ашиглана.

2.3.2 Бусад оролцогчдын санаа бодлыг сонсох, хариултыг хэлэлцүүлэг болгон өрнүүлэх арга:

Сургагч багш та оролцогчдын хариултыг сонсож байхдаа тэдний сэтгэлгээг нээж өгөхийн тулд бусад хүмүүс энэ санааны талаар юу бодож байгааг асуух хэрэгтэй. Бусдынхаа дэвшүүлсэн асуудал, санааг илүү сайн ойлгох, улмаар ташаа ойлголтын талаар илүү сайн тунгаах боломж олгоно. Тухайлбал, “Түүний хариултын талаар та юу бодож байна?” “Та түүний хариултыг илүү нарийвчилсан байдлаар, эсвэл энгийнчилж ойлговол яаж илэрхийлж хэлэх вэ” “Та бидний сонссон бүх хариултыг нэгтгээд нэг өгүүлбэрээр юу гэж хэлмээр байна?” гэх мэтээр нэг талаас оролцоог хангах, нөгөө талаас санаа бодлыг нэгтгэх, ойлголтын зөрүүг гаргах, дүгнэлт хийхийг оролцогчдоор гүйцэтгүүлж буй хэрэг юм.

2.3.3 Чиглүүлэх асуултууд:

1. Малын бэлчээрт тавих шаардлага

Сургагч багш та малчин иргэдэд сургалт зохион байгуулахдаа тэдний санаа бодлыг сонсож, туршлагаасаа хуваалцах боломжийг олгоорой. Сургалтын сэдэлжүүлэлт хийх зорилгоор багш өөрөө чиглүүлэх асуултууд бэлдсэн байх шаардлагатай. Жишээ нь:

- Танай ашиглаж байгаа бэлчээр сүүлийн 3 жилийн хугацаанд хэрхэн өөрчлөгдөж байгаа вэ?
- Бэлчээр ургаж байгаа ургамлын хэдэн хувийг та өөрөө мэдэх вэ?
- Бэлчээрийн даац хэтрээд байгаа тохиолдолд малчдын зүгээс ямар арга хэмжээ авах нь зөв бэ?
- Газрын даамлын хийсэн мониторингийн судалгааны үр дүнг харж байсан уу?
- Танай аймаг, сум малчид бүлэг хэсгийн зохион байгуулалтад орсон уу? Хэчнээн хэсэг бүлэг бий болсон бэ?
- Бэлчээр ашиглалтын гэрээ байгуулах талаар сонсож байсан уу?
- Малчдын бүлэг, хэсэг байгаа тохиолдолд: Танай хэсэг бүлэг сумын засаг даргатай бэлчээр ашиглалтын гэрээ байгуулсан уу?
- Тайна аймаг суманд бэлчээр ашиглалтын талаар ихэнхдээ ямар маргаан зөрчил бий болж байна. Түүнийг хэрхэн зохицуулж байна?

- Сумын газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд бэлчээрийн менежментийн үйл ажиллагаанууд тусгагддаг уу?
- Доройтсон бэлчээрийг сайжруулахад ямар арга хэмжээ авах шаардлагатай байна вэ?

2. Малын тэжээллэг, арчилгаа, маллагаанд тавих шаардлагын чиглэлээр:

НЭГ. Та өөрийн эзэмшиж, ашиглаж байгаа өвөлжөө, хаваржаа орчмын ус, бэлчээрийг хэрхэн зөв сонгож, ашиглаж байна бэ ?

Өвөлжөө	Тийм	Үгүй	Хаваржаа	Тийм	Үгүй
Өвөлжөөндөө хужир шүү элбэгтэй, нөмөр нөөлөг сайтай, өвс ургамал нь ургаа хэвээрээ байдаг бэлчээрийг сонгож авсан			Хаваржаандаа хэтэрхий их уулархаг биш намдуу газрын задгай бэлчээрийг сонгож авсан		
Өвөлжөөний тойромтой			Эр сувай малаа алсын оторт явуулдаг		
Өвөлжөөний ойр орчимд хашиж хамгаалсан хадлангийн талбайтай			Цаг агаар хүндэрсэн тохиолдолд отрын бүс нутагт юм уу, өөр аймаг, сумын нутагт отор нүүдэл хийх гэрээг Засаг даргатай хийдэг		
Бэлчээрээ холын, ойрын, нөөц хэмээн зааглан ялгаж өдөр тутам хуваариар, нэг захаас нөгөө зах хүртэл бүрэн ашигладаг эсэх			Хаваржаа орчмын бэлчээрийг хол, ойрын гэж зааглан ялгадаг		
Цас эрт унадаг алс зайдуу бэлчээрээ түрүүлж, ойр дөт бэлчээрээ цаг агаар хүйтэрч, өвөлжилт хүндрэх үед ашигладаг			Хаваржаа орчмын бэлчээрийг намраас эхлэн малын хөлд талхлуулахгүй байх талаар анхаардаг		
Тэнгэр цэлмэг дулаахан үед уулын хөндий, бэл, ил цагаан, цармын бэлчээрийг, салхи шуургатай хүйтэн өдөр наранд эзвэр толгодын энгэр, мод бут, хад цохионы хаацтай бэлчээрийг ашигладаг			Төллөсөн буюу хээл нь хүндэрсэн малд ойрын бэлчээрийг, эр сувай малдаа холын бэлчээрийг ашиглуулдаг		
Урин дулааны үед худаг болон харзны усаар услах боломжтой			Дулаахан салхи жаваргүй өдөр төл малыг эхээс нь ялгаж хаваржааны ойр орчимд бэлчээх, задгай ус уулгах боломжтой		

ХОЁР. Танай малын хашаа, байр шаардлагад хэр зэрэг нийцэж байна бэ ?

Өвөлжөөний хашаа, байр	Тийм	Үгүй	Хаваржааны хашаа, байр	Тийм	Үгүй
Ус, бэлчээр, хужиртаа ойрхон			Өвөлжөөндөө ойрхон		
Нар ээвэрлэг, сүүдэр орой буудаг			Алсын салхи, жаваргүй, нөмөрлөг		
Хуурай эр хөрстэй, өмнө, баруун, зүүн тийш бага зэрэг хэвгий, салхины дээд талаар хэсэг хэсэг хөндлөн ухаа, хяр толгодтой тэгш газрыг сонгосон			Отор нүүдэлд талхлагдаагүй, хөлийн замаас зайдуу, ус чийг нэвчдэггүй хуурай хөрстэй, задгай ус, алс тэнүүн бэлчээртэй газрыг сонгосон		
Нэг толгой бог малд 0.5 хав.дөр. метр талбай, нэг бодод 2.5 хав.дөр. метр талбай ногдохоор тооцож, хашаа, байраа барьсан			Шар усны үер буудаг жалга суваг, судгаас зайдуу		
Бод малын хэвтэрт хуурай бууцтай, нөмөр хороотой, орчин тойрондоо хужир, марз тойромтой, дэрс цахилдаг, хамхуул, бут бударганатай нам дор хонхор газрыг сонгож авсан			Төлийн пүнзийг саравчтай хашааны хажууд салхины урсгал цохилтыг харгалзан урагш харуулан нар өдөржин тусаж байхаар барьсан		
Цаашид малын тоо нэмэгдэхэд хашаа, байраа өргөтгөж, тохижуулах боломжтой			Нэг толгой бог малд 1.0 хав. дөр.метр талбай, нэг бодод 3.0 хав.дөр.метр талбай ногдохоор тооцож, хашаа, байраа барьсан		
Хөрзөнгөө ховхолж сараалж хайсанд хураах юм уу хашаа хороогоо тойруулан нуруулдаж хатаагаад ирэх жилийн түлшинд хэрэглэдэг			Хөлдүү хоргол, нойтон шар бууц өтгийг өдөр бүр хусан авч хаалт хашлаганд хийж овоолох ба малын хэвтрийг хуурай хөх бууцаар байнга сольдог		
Малын хашаа, байрны орчмыг байнга цэвэрлэж, хог хаягдал, сэг зэмийг тусгай нүхэнд булж устгадаг			Эх малын эхэс, судас, хээлийг устгаж ариутгах зориулалтын нүхтэй		
Өвсний задгай хашаа, тэжээлийн битүү агуулах байгаа юу.					

ГУРАВ. Та мал сүргээ зөв, сайн хариулж, маллаж байна уу ?

Урин дулааны үед (хавар, зун)	Тийм	Үгүй	Хүйтэн сэрүүний улиралд (намар, өвөл)	Тийм	Үгүй
Өөрийн ашиглаж буй бэлчээрийн болон сум, багийн нутагт ургадаг малын тэжээлийн гол гол ургамлуудыг таньж мэддэг			Малаа бэлчээхдээ бут бударгана, ганга, хазаар, хиаг, агь, ботууль, ерхөг, шаваг,баглуур дэрс бүхий бэлчээрийг ашигладаг		
Бэлчээрийн ургамлын төрөл, ургацын байдлаар сэлгэн нүүдэллэж, нэг нутаг буурины бэлчээрийг өглөө, орой, өдрийн халуунд гэх маягаар хуваарилан хариулж малладаг			Цастай үед алсаас харахад хүрэлтэн борлож байгаа уулын бэл, толгод, нуруу, ухаа, энгэр, өглөө оройны нарны тусгал сайтай бэлчээрт малаа хариулдаг		
Уулархаг нутагт уулын ар цармын сүүдэр огшилтыг дагуулан, тал нутагт нар тосуулан бэлчээж, халуунд эргүүлэн буцааж хариулдаг			Цэлмэг дулаан үед уулын хөндий, бэл, тал цагаан газар малаа бэлчээдэг		
Урин дулааны бэлчээрийн ногоо шүүс ихтэй байдаг ч малаа өдөрт нэг удаа бага үдийн алдад бэлчээрээр усалдаг			Бүрхэг шуургатай өдөр өвөлжөө хотондоо ойр хонхор, хотгор гуу жалга, нам дор газрын бэлчээрт хариулдаг		
Зам харгуй дагуулан хариулах, уулын бэрхлэг өөд мацуулах, газрын уруу цочмог буулгахаас сэргийлдэг			Хужир байнга идүүлэх юм уу бэлчээртээ хужиртай тул долоо хоногт нэг удаа хужирт оруулдаг		
Малаа усалсны дараа өдрийн халуунд амрааж, сэрүү орсны дараа бэлчээдэг			Хээрийн цас, мөсний хайланг ус уулшаж, түүний дороос ил гарах ургаа соргог бог өвс дагуулан хариулж малаа гэдэслүүлдэг		
Өсвөр насны малын суурьт цөөн тооны бүдүүн мал оролцуулан суурилж малын бэлчээрлэлтийг тогтворшуулан малдаа тарга хүч авхуулдаг			Ногоонд цадах үеэр өдөр бүр услалгүй нэг хоёр өнжөөд усалж ханатал нь ус уулгаж хүч тэнхрэл авхуулдаг		
			Монгол мал ерөнхийдөө таруу идээшлэх дуртай байдгийг харгалзан алсаар нь тойрон явж аажмаар дотогшлуулах байдлаар хариулдаг		

ДӨРӨВ. Та мал сүргийнхээ өвс, тэжээлийн хэрэгцээг тогтоож, тэжээлийн нөөц хангалттай бэлтгэн малаа зөв тэжээж байна уу ?

Тэжээлийн хэрэгцээ нөөц	Тийм	Үгүй	Мал тэжээх арга	Тийм	Үгүй
Малсүргээхонинтолгойдшилжүүлэн тухайн онд хэдэн тонн өвс хадлан бэлтгэхээ төлөвлөж байгаа			Малын тэжээлийн модон сараалж байгаа		
Энэ жил хадаж бэлтгэсэн байгалийн хадлан болон худалдаж авсан өвс ирэх хаврын ногоо гартал 150–180 хоног тэжээхэд хүрэлцэнэ			Сүрлийг дангаар нь юм уу бусад тэжээлтэй хольж амтлан малаа тэжээдэг		
Эзэмшиж болон ашиглаж буй хадлангийн талбайгаа цэвэрлэж, хашиж хамгаалсан			Бүдүүн тэжээлийг нэг бог малд өдөрт 500 грамм, бод малд 1 кг ногдохоор тооцож цаг хүндэрсэн үед угтуулан тэжээдэг		
Хадлан хадах бэлтгэлээ байнга сайн бэлтгэдэг:			Бүрхэг шуургатай өдөр өвөлжөө хотондоо ойр хонхор, хотгор гуу жалга, нам дор газрын бэлчээрт хариулдаг		
–шимээсэг хадуур 2 ш			Хужир байнга идүүлэх юм уу бэлчээртээ хужиртай тул долоо хоногт нэг удаа хужирт оруулдаг		
–Морин тармуур 1 ш			Хээрийн цас, мөсний хайланг ус уулшаж, түүний дороос ил гарах ургаа соргог бог өвс дагуулан хариулж малаа гэдэслүүлдэг		
–Өвсний сэрээ 4 ш			Ногоонд цадах үеэр өдөр бүр услалгүй нэг хоёр өнжөөд усалж ханатал нь ус уулгаж хүч тэнхрэл авхуулдаг		
–Ирэлгээний дөш, алх, хуурайтай гэх мэт			Эрдэс тэжээлийг бог малд өдөрт 10 грамм, бод малд 30 грамм өгдөг.		
Цаашид хадлан бэлтгэх ажлаа механикжуулна			Ам хужрыг хүйтний улиралд 2 өнжөөд 1 удаа, урин дулаанд 7 хоногт 1 удаа хужирладаг		
Бага оврын трактор авна			Зөөврийн хужрыг байнга тавьж өгдөг		

Бага оврын хадуур авна			Төлийн байранд хужрын шахмал, төрөл бүрийн өвсний зоодойг дүүжилж төлд байнга долоолгодог		
Бага оврын тармууртай болно			Витаминаар баялаг өвсийг хадаж хатаагаад жижиглэн хэрчиж хандлан ядарч доройтсон юм уу өвчтэй төл, том малд өгдөг		
Малынхаа хэрэгцээний хэрээр жил бүр 5 тонн хүчит тэжээл нөөцөлнө					
Төрөл бүрийн өвс, сүү, цагаан идээг ашиглан жилд 300–500 кг гар тэжээл бэлтгэнэ					

ТАВ. Та төл хүлээн авах, бойжуулах бэлтгэл ажлаа яаж хангадаг бэ ?

Төл хүлээн авах, бойжуулах бэлтгэл	Тийм	Үгүй
Мал хээлтүүлгийн хугацааг орон нутагтаа баримталж байгаа		
Эцэг малыг тусгай суурилуулан маллаж байгаа		
Төллөх малын 20%–д хүрэлцэхүйц төлийн нэмнээ, элгэвч бэлтгэсэн		
Төлийн уут 2 ш–ийг бэлтгэсэн		
Төлийн угж 5 ш–ийг бэлтгэсэн		
Хээл хүндэрч байгаа үед гуу жалга, бартаагүй нам дор газар үргээж цочоолгүй тогтуун зөөлөн үед хариулдаг		
Хээлтэй малаа хээр задгай ус, хужирт оруулахыг чухалчилдаг		
Нялх төлийг цаг алдалгүй эхийн уураг сүүнд сайн цадтал амлуулдаг		
Эх малын дэлэн хөхийг сайтар арчилж, төлийг зөв хөхүүлдэг		
Үр төлөө голсон юм уу эх нь үрэгдсэн малд төлийг авхуулдаг		
Эх мал шилбэ муутай төрсөн үед төлд төрөл бүрийн малын сүүг өгөх, сүү орлох тэжээл өгдөг		
Төлийн эрдэс тэжээлийн долооц 8–10 кг бэлтгэсэн		

3. Малын эрүүл мэндийн чиглэлээр:

- Малын эрүүл мэндийн зохистой дадал гэж юу вэ?
- Зохистой дадал нэвтрүүлэх зорилго юу вэ?
- Мал сүргийг эрүүл байлгах гол зорилго юу вэ?
- Малын гоц халдварт болон зооноз өвчингүй мал сүрэгтэй байхын ач холбогдол?
- Сүрэгт гаднаас халдвар дамжих эрсдэл хэрхэн бий болох вэ?
- Малын өвчнийг эрт илрүүлэх, шуурхай хариу арга хэмжээ хэрэгжүүлэх, тархалтыг хязгаарлах гэж юу вэ?
- Малын эрүүл мэндийн түүхийг мөшгөх нөхцлийг бүрдүүлэх гэж юу вэ?

4. Малын нөхөн үйлдвэрлэл, үржүүлэг селекции чиглэлээр:

Сургагч багш та малчин иргэдэд сургалт зохион байгуулахдаа тэдний санаа бодлыг сонсож, туршлагаасаа хуваалцах боломжийг олгоорой. Сургалтын сэдэлжүүлэлт хийх зорилгоор багш өөрөө чиглүүлэх асуултууд бэлдсэн байх шаардлагатай. Жишээ нь:

- Танай аймаг, суманд дийлэнх үржүүлдэг нь ямар төрлийн мал вэ?
- Танайх мал сүрэгтээ бүртгэл хөтөлдөг үү?
- Дийлэнх үржүүлж байгаа малд давуу тал байна уу?
- Дийлэнх үржүүлж байгаа малд сул тал байна уу?
- Нэг малаас авч байгаа ашиг шимийн гарцаар ямар төрлийн мал илүү байна вэ?
- Нэг малаас авч байгаа ашиг шимийн мөнгөн дүн ямар төрлийн малд илүү байна вэ?
- Нэг малаас авч байгаа ашиг шимийн чанараар ямар төрлийн мал илүү байна вэ?
- Малын амьдын жин дунджаар ямар байна. Буурч байна уу?, нэмэгдэж байна уу?
- Малын гулуузны жил хэд орчим байдаг вэ?
- Мал сүрэгт жил бүр тогтоосон хугацаанд ангилалт хийлгэж, шилэн сонголт, заазлалтыг тогтмол хийж байна уу?
- Үржлийн малаа хэрхэн сонгож авч байгаа вэ?
- Хээлтүүлэгч малаа хаанаас авдаг вэ?
- Танай сүрэгт ямар нас хүйсний мал зонхил байна вэ?
- Жилдээ ямар төрлийн, хэчнээн мал зах зээлд нийлүүлдэг вэ?
- Төл бойжилт малын төрөл бүрээр хэдэн хувьтай байгаа вэ?

5. Малын гаралтай түүхий эд бэлтгэл чиглэлээр

- Танай аймаг, суманд дийлэнх үржүүлдэг нь ямар төрлийн мал вэ?
- Танайх мал сүрэгтээ бүртгэл хөтөлдөг үү?
- Дийлэнх үржүүлж байгаа малд давуу тал байна уу?
- Дийлэнх үржүүлж байгаа малд сул тал байна уу?
- Нэг малаас авч байгаа ашиг шимийн гарцаар ямар төрлийн мал илүү байна вэ?
- Нэг малаас авч байгаа ашиг шимийн мөнгөн дүн ямар төрлийн малд илүү байна вэ?
- Нэг малаас авч байгаа ашиг шимийн чанараар ямар төрлийн мал илүү байна вэ?
- Малын амьдын жин дунджаар ямар байна. Буурч байна уу?, нэмэгдэж байна уу?
- Малын гулуузны жил хэд орчим байдаг вэ?
- Мал сүрэгт жил бүр тогтоосон хугацаанд ангилалт хийлгэж, шилэн сонголт, заазлалтыг тогтмол хийж байна уу?
- Үржлийн малаа хэрхэн сонгож авч байгаа вэ?
- Хээлтүүлэгч малаа хаанаас авдаг вэ?
- Танай сүрэгт ямар нас хүйсний мал зонхил байна вэ?
- Жилдээ ямар төрлийн, хэчнээн мал зах зээлд нийлүүлдэг вэ?
- Төл бойжилт малын төрөл бүрээр хэдэн хувьтай байгаа вэ?

2.3.4 Кейс тохиолдлыг задлан шинжлэх арга зүй:

Дараах кейс тохиолдлуудыг уншаад задлан шинжилж, ярилцан, багаар ажиллах

Кейс –1

“Бэрх” малчдын бүлэг, хэсгийн бэлчээрийн газрын талбайн хэмжээ ойролцоогоор уртаашаа 10км, өргөөшөө 5км гэж үзвэл нийт бэлчээрийн хэмжээг хэрхэн тооцох вэ? Бэлчээрийн нийт хэмжээгээ тооцож гаргахын ач холбогдол юу байгаа талаар санал сэтгэгдлээ хуваалцаарай


Кейс –2

Малын хашаа байрыг малын төрөл, тоо толгой, байгаль цаг уурын онцлог, улирлын байдалд тохируулан, хүрээлэн буй орчны болон малын эрүүл ахуйд нийцүүлэн барьж байгуулдаг. Тэгвэл нэг толгой бог малд хэдэн хавтгай дөрвөлжин метр талбай, нэг бодод хичнээн хавтгай дөрвөлжин метр талбай ногдох вэ? Малчин өөрийн малын тоонд тохирох хашааны хэмжээг тооцож гаргах юм.

Кейс –3

Дархлаажуулалт, угаалга, туулга, боловсруулалт зэрэг нэгдсэн арга хэмжээ болон эмийн эмчилгээний дараа хүлээх хугацааг үйлчилгээ үзүүлсэн малын эмч тогтоох бөгөөд уг хугацаа дуусаагүй үед малын мах, сүүг зах зээлд нийлүүлэхээс татгалзана. Малчин гэрээт малын эмчийн зөвлөмж зааварчилгаагүйгээр эм, химийн бэлдмэл худалдан авах, зориулалтын бус нөхцөлд хадгалах, малын эмчилгээнд дур мэдэн хэрэглэх боломж бий юу? Энэ тохиолдолд ямар арга хэмжээ авч хэрэгжүүлэх вэ?

Кейс –4



Малчин Дандар 40 хонинд нэг хуц тавьдаг бол Болд 60 хонинд нэг, Даш 80 хонинд нэг байхаар тооцож үржлийн хуцаа тавьдаг. Дээрх малчдын хэн нь хээлтүүлэгчийн нормыг зөв тааруулсан вэ? Малчин Дандар тэрээр энэ жил хээлтүүлэгт оруулах 480 эм хоньтой тул түүнд хичнээн хуц хэрэг болох вэ? Тэрээр үржилд ашиглах хуцаа хаанаас авах нь зохимжтой гэж та үзэж байна вэ?

2–3 оролцогчийг баг болгон, багт кейсийг өгч, тооцоолол хийлгэж, асуултад хариулахдаа бодлоо цэгцлэх, хариултаа олох боломжийг олгоно. Малын төрөл тус бүрээр өрхийн хэмжээний хээлтүүлэгчийн хэрэгцээг тооцож гаргах ба улмаар бүлэг, хэсэг, баг, сумын хэмжээний жийлийн хэрэгцээг тооцож гаргах зэргээр ярилцан, хүрэлцээ, хангамжийн талаар тэдний санал бодлыг сонсох байдлаар сургалтыг үргэлжлүүлнэ.

Кейс –5

Ноолуурыг бэлтгэхдээ цагаан, цагаан цайвар, цайвар, бараан гэж 4 өнгөөр, дээд, I, II, III гэж чанараар мөн борлон, нас гүйцсэн гэх зэргээр насаар нь ангилж бэлтгэдэг. Өнгө болон насаар ангилахын давуу болон сул юу вэ?

Ноолуурыг чанараар ангилахын ач холбогдол юу гэж та үзэж бамйна вэ?

Оролцогчдын санаа бодлыг сонсох, хариултыг нэгтгэхдээ баримтлах зарчим

“Хүлээх зарчим”

Оролцогчдод бодох хугацаа олгох ба ингэснээр хариултаа бэлдэнэ. Нэгэнт бүх оролцогч нэг ижил хурдаар эсвэл нэг ижил аргаар сэтгэхгүй тул хугацаа хүлээх нь асуултад хариулахдаа бодлоо цэгцлэх, хариултаа олох боломжийг олгоно. Мөн хариулт дууссаны дараа зөв, буруу, ингээд бодоход гэх мэтээр яаран нэгтгэл хийхээс өмнө хэсэг зуур хүлээгээрэй. Энэ нь тухайн оролцогчид хариултаа нарийвчлан бодох, үргэлжлүүлэх боломж олгоно, эсвэл өөр хүн хариулах боломж гарна.

ГУРАВ. СУРГАЛТЫН ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

3.1 Танхимын бус сургалт үйл ажиллагааны тухай

Сургалтын явцад багш, оролцогч иргэдтэй эргэх холбоотой байх бөгөөд танхимын бус үйл ажиллагааг ч мөн хамтдаа зохион байгуулах боломжтой. Танхимын бус сургалтын үйл ажиллагааг явуулахаас өмнө багшийн өгсөн даалгавар, төслийг оролцогчид багаараа гүйцэтгэх бөгөөд урьдчилан багийн ажлын төлөвлөлт хийх, ажлаа хуваарилах, танхимаас гадуур ажиллах орчин нөхцөлийг бүрдүүлэх зэрэгт багш анхаарна. Мөн төсөл, даалгаврыг гүйцэтгэхэд шаардлагатай дэмжлэгийг үзүүлнэ. Ялангуяа сургалтаас гадуурх багийн ажил, төсөлт ажлыг гүйцэтгэхэд эзэмшсэн мэдлэг, чадвар, сэтгэлгээг бодит нөхцөлд буулгах, хэрэглэхэд түлхүү анхаарах хэрэгтэй. Танхимаас гадуур гүйцэтгэх ажлын удирдамжийг сургагч багш дэлгэрэнгүй байдлаар гаргаж, оролцогчид түүнтэй урьдчилан танилцсан байх шаардлагатай. Оролцогчдын мэдлэг, чадвар, сэтгэлгээг зөвхөн танхимын сургалтын үйл ажиллагаагаар дамжуулан хөгжүүлэхэд хангалттай бус учраас төсөлт ажил байдлаар, тодорхой дадлага ажлыг багийн зохион байгуулалт, багийн оролцоо, чиг үүргээр дамжуулан хөгжүүлэх хэрэгтэй. Жишээ нь: Оролцогчдыг саахалт болон ойролцоо оршин байгаа баг, хороогоор нь, эсвэл хүсэл эрмэлзэл, сонирхлоор нь баг болгон хувааж, багууд жижиг компани, хоршоо хэлбэрийн зохион байгуулалттайгаар ажиллан дараах үйл ажиллагаанд оролцох байдлаар сургалтын үйл ажиллагааг идэвхтэй хэлбэрээр зохион байгуулж болно. Үүнд:

- Бие даасан ажил
- Хос хосоороо ажиллах
- Багаар ажиллах
- Кейсүүдийг цуглуулах
- Дүн шинжилгээ хийх
- Танхимаас гадуур суралцах
- Орон нутгийн аж ахуйгаар зочлох, өрхийн үйлдвэрлэлээ нэмэгдүүлэх боломж, санааг олж авах
- Шийдвэр гаргагчид болон хөдөө аж ахуйн маркетинг, менежментийн чиглэлийн мэргэжлийн холбоодын төлөөллийг сургалтад урилгаар оролцуулах, төсөл хөтөлбөрт оролцох, жижиг үйлдвэрлэл эрхлэх зөвлөгөөг авах
- Илтгэл, танилцуулга хийх
- Мэдээлэл харилцааны технологи ашиглах гэх мэт.

3.2 Харилцан суралцах аргаар сургалтыг зохион байгуулах нь:

Энэхүү сургалт нь оролцогчид бие биеэсээ харилцан суралцах арга зүйгээр зохион байгуулагдана. Оролцогчид нутаг нутгийн болон бусдынхаа сайн туршлагыг олж нээх, хамтран суралцах, сайн туршлагыг хямд зардлаар олж эзэмших үйл явц юм. Харилцан суралцах арга нь мэдлэг, мэдээлэл хуримтлуулах, шинэ нөхцөл байдалд асуудлыг шийдэх, шинэ мэдлэг бүтээх, шинэ хэрэглэгчид дамжуулах бүтээлч арга юм. Сургалтаар эзэмшсэн мэдлэг тухайн үедээ шууд хэрэглэгдэж үр дүнг харуулах нь цөөн байдаг бол харилцан суралцах аргаар эзэмшсэн мэдлэг шууд ажилд туршигдан үр дүнг мэдрэх боломжтой байдгаараа онцлогтой. Жишээ нь: Оролцогчдод урьдчилсан даалгавар өгөөд, ноос ноолуур боловсруулж, бүтээгдэхүүн үйлдвэрлэж, өрхийнхөө хэрэгцээг хангаж байгаа иргэдийн туршлагыг богино хэмжээний бичлэг хийж ирэх даалгавар өгч, сургалтын үеэр түүнийгээ хэлэлцэх, тайлбарлах зэрэг бүтээлч даалгавраар идэвхжүүлж болох юм. Оролцогчдын сайн туршлагыг хуваалцах арга зүйг дараах байдлаар хэрэгжүүлж болно.

Сайн туршлагыг тодорхойлох, хуваалцах алхам

Сургалтад оролцогчдыг хагас дугуй хэлбэрт оруулж зогсоогоод багш (чиглүүлэгч, сургагч багш) бусдын сайн туршлагыг тодорхойлох, тухайн туршлагыг хуваалцах үе шатыг дараах алхмын хамт тайлбарлана

1. Сайн туршлагыг тодорхойлох

“Сайн туршлагыг тодорхойлох” алхмуудыг бичсэн (түлхүүр үгээр) цаасыг байрлуулаад тухайн алхам бүрийг тайлбарлана. Багш туршлагыг тодорхойлох шалгуур үзүүлэлтийг тайлбарлаж өгнө. Өөрсдийн туршлагаа бусадтай хуваалцахаар төлөвлөж буй хүмүүс хамтран ажиллагсад, орон нутгийн иргэдтэй харилцан ярилцаж, хэлэлцэх байдлаар дараах асуултад хариулж сайн туршлагаа тодорхойлно.

- Тухайн туршлагын давуу ба сул талууд, мөн эрсдэлийг тооцоолсон байдлаар тодорхойлон, ярилцах юм. Хэдийгээр сайн туршлага гэж байгаа боловч, хэрэгжүүлэх явцад эрсдэл гарч болох тул сул тал байхыг үгүйсгэх аргагүй юм. Малчдын амьдрах ухааны чадварыг дэмжих, нийгмийн хамгааллыг өргөжүүлэх дэд
- Тухайн сайн туршлагыг түгээн дэлгэрүүлэх боломжтой юу? /Жишээ нь өртөг өндөртэй туршлагыг бусад газарт хэрэгжүүлэхэд нэн ярвигтай байдаг/
- Энэ туршлагыг хэрэгжүүлээд ямар үр дүнд хүрч болох вэ?
- Энэ туршлагыг хэрэгжүүлсний дараа аливаа үйл ажиллагаа, үйлчилгээг сайжруулах боломжтой юу? Хэрэв эдгээр шалгуур үзүүлэлтүүдийг хангаж байвал энэ нь хэрэгжүүлж болохуйц сайн туршлага болж чадна.

2. Сайн туршлагыг хуваалцахын ач холбогдол

Дараа нь сургагч багш малчин иргэдэд өөртөө байгаа сайн туршлагаа зөвхөн өөрсдийн сайн сайхны төлөө хэрэглээд зогсохгүй үүнийгээ бусадтай хуваалцаж, нийгэмд өөрсдийн хувь нэмрээ оруулах хэрэгцээ шаардлага, ач холбогдолтой байгаа талаар тайлбарлана.

3. Сайн туршлагаас суралцах буюу юуг, хэрхэн хэрэгжүүлэхээ шийдэх, төлөвлөх

Багш самбар дээр “Сайн туршлагаас суралцах” гэж бичсэн түлхүүр үгийг байрлуулна. Дараа нь сайн туршлагаас суралцах алхмыг тайлбарлаж өгөөрэй. Үүнд:

- Хэрэгжүүлэх боломжтой гэж үзсэн сайн туршлагыг малчидтай хамтран хэлэлцэж тухайн туршлагын давуу болон сул тал, орон нутгийн болон өрхийн түвшинд ямар эерэг үр дүн гарахыг тодорхойлно.
- Магадгүй хоёр ба түүнээс дээш сайн туршлага байгаа бол эрэмбэ үүсгэх байдлаар сайн туршлагыг сонгон авна.
- Сайн туршлагыг бүтээсэн хувь хүн, орон нутагт очиж туршлага судална. Ийнхүү тухайн туршлагыг хэрэгжүүлсэн бодит байдлыг судлах нь орон нутаг, тухайн өрх гэрт бий болсон өөрчлөлт, сул болон давуу талыг дэлгэрүүлэн судалж, шийдвэрээ эцэслэн гаргахад дэмжлэг үзүүлнэ.

4. Сайн туршлагыг бусадтай хуваалцах

Сайн туршлагыг бусадтай хуваалцахдаа ойлгомжтой, дэлгэрэнгүй байдлаар бусдадаа тайлбарлаж өгөхийг сануулаарай. Оролцогчийн туршлагыг өөрийн нөхцөлд тохируулан хэрэгжүүлэх явцад сонсож буй хүлээн авагч талд ойлгомжгүй асуудал цөөнгүй тохиолдоно. Ийм нөхцөл байдал үүсвэл сайн туршлага бүтээсэн талтай холбоо тогтоон асууж лавлах эсвэл зөвлөх, урих ажлыг зохион байгуулж болох юм. Өөр орон нутагт амжилттай хэрэгжсэн үйл ажиллагаа танайд амжилтгүй хэрэгжиж болзошгүй. Иймд туршлагыг тухайн орон нутгийнхаа онцлогт тохируулж хэрэгжүүлэх шаардлагатайг сургалтад оролцогчдод онцгойлон ойлгуулах хэрэгтэй.

5. Сайн туршлагад тулгуурлан бодлогын нөлөөллийг бий болгох

Сайн туршлагаас суралцах, өөрийн болгох үйл явцад хяналт тавьж үнэлгээ хийж болно. Тухайн сайн туршлагыг хэрэгжүүлсэн багуудтай хамтран бодлогод өөрчлөлт оруулах алхмыг хийх нь туршлагыг хэрэгжүүлэхтэй холбоотой алдаа давтагдахгүй байх боломжийг бүрдүүлнэ. Туршлага солилцох үйл ажиллагааны төгсгөлд сургагч багш сайн туршлагыг тодорхойлох, тухайн туршлагаас хэрхэн суралцах, үе шат бүрт хийгдэх алхмыг зөв чиглүүлж, оролцогчдыг нээлттэй байлгах тал дээр анхаарах ёстой бөгөөд бодит видео хичээл, билэг, зураг дээр тайлбарлаж дүгнэж явбал илүү үр дүнд хүрнэ. Оролцогчдыг хагас дугуй хэлбэрт оруулж зохион байгуулж байгаа нь бие биеэ сонсох, хүлээн зөвшөөрөх, харилцан тэгш эрхтэй байх сэтгэлзүйн орчныг бүрдүүлж буй хэрэг юм. Дараах хүснэгтийн дагуу баримт мэдээллээ цуглуулж авбал өрхийн туршлагууд бодитоор өвлөгдөн үлдэх боломжтой юм.

Сайн туршлагын баримтын товч хүснэгт

Сайн туршлагын нэр		
Хэрэгжүүлсэн гол үйл ажиллагаа		
Хүрсэн үр дүн (гарсан өөрчлөлтийг нотлох тоо баримт)		
Ашигласан нөөц	Мэргэжил арга зүй, хүний нөөц	Хөрөнгийн эх үүсвэр
Холбоо барих хаяг		
Мэдээлэл өгөх хүний нэрс		

Сайн туршлагын баримтын дэлгэрэнгүй хүснэгт

Сайн туршлагын нэр		
Нөхцөл байдал тулгамдсан асуудал		
Зорилтот бүлэг		
Шалгуур үзүүлэлт (төлөвлөлт, хэрэгжилт, үнэлгээ)		
Ашигласан хэрэгсэл		
Хүрсэн үр дүн (гарц, богино хугацаанд гарсан өөрчлөлтүүд)		
Үр дүнг тогтворжуулахаар хийсэн алхмууд		
Тулгарсан бэрхшээл, эрсдэл		
Амжилтад нөлөөлсөн хүчин зүйлс		
Үр шим хүртэгчдийн сэтгэгдэл		
Туршлагыг түгээн дэлгэрүүлэхэд анхаарах зүйлс		

Тулгарч болох бэрхшээл, шийдвэрлэх аргууд

1. Сургалтын үеэр бүлгүүд ижил төрлийн сайн туршлагыг сонгож давтан ярьснаар сургалтыг уйтгартай болгох үед: Бүлэг тус бүрийг дараалуулан яриулахдаа туршлага давхцуулахгүй байх

2. Сургалтын үеэр цаг хүрэлцэхгүй бол: Хэрэв сургалтын төлөвлөгөө зөв боловсруулагдсан бол чиглүүлэгч төлөвлөгөөний дагуу цагийг баримтлан ажиллах ба цаг хүрэлцэхгүй байх асуудал гардаггүй.

3. Сургалтын туршид зарим оролцогчид “чимээгүй” байдаг. Яаж “нүүр хагарах” вэ? Хэрэв “чимээгүй” оролцогчид байвал тэдэнд бусадтайгаа, олны өмнө гарч, санаа бодлоо хуваалцах санал тавьж болох юм. Ингэснээр тэд ямар бодол, саналтай байгаагаа бусад оролцогчидтой хуваалцах боломжтой болно. Хэрэв тэд цаашид хийгдэх үйл ажиллагаа болон илтгэлтэй холбоотой өөрийн санал бодлоо хуваалцахдаа тааламжтай бус байвал тэднийг өөртөө тохиолдсон ямар ч төрлийн эерэг туршлагаа хуваалцахыг хүсэж болно. Үүний дараа тэд илүү идэвхжиж, чөлөөтэй оролцож эхэлнэ.

4. Сайн туршлагыг тодорхойлох шалгуур үзүүлэлтүүд

- Уламжлалт аргуудыг сэргээн, шинэчилж, өвлүүлж буй байдал
- Шинэлэг, үйлчилгээг сайжруулахад дэмжлэг үзүүлж буй
- Тогтвортой хөгжлийг дэмжиж буй
- Нийгэмд, бусад айл өрх, иргэдэд хүлээн зөвшөөрөгдөх
- Түгээн дэлгэрүүлэх/суралцах боломжтой байх
- Технологийн хувьд боломжтой
- Оролцоог хангасан, эдийн засгийн хувьд боломжтой

5. Шилдэг туршлага гэж: Монголын нөхцөлд аливаа сайн туршлага олон удаа хэрэгжсэн тохиолдолд “Шилдэг туршлага” гэж тооцож болно. Сайн туршлагыг хэрэгжүүлэх явцад тулгарсан бэрхшээлийг шийдвэрлэхдээ туршлага түгээж буй хувь хүн, байгууллагаас зөвлөгөө авч, хамтран ажиллах хэрэгтэй. Ингэснээр та бүхний сонгосон “сайн туршлага” үр өгөөжтэй хэрэгжих юм.

Дадлага ажил

1. Малын бэлчээрт тавих шаардлага

Сургалтад оролцогчдыг баг болгон хувааж дараах дадлага ажлуудыг гүйцэтгүүлж задлан шинжилгээ хийлгэх, ярилцлага зохион байгуулах зэргээр багаар ажиллуулна.

Дадлага –1

Сургалтад оролцогчдыг 3 баг болгож нэг малчдын бүлгийн түвшинд бэлчээр ашиглалтын хүрээнд үүсдэг 3 өөр асуудлуудыг кэйс болгон өгөх ба багууд өөр өөрсдийн оногдсон кэйс асуудлуудад задлан шинжилгээ хийж түүнд тохирсон бэлчээрийн менежментийн төлөвлөгөөний төсөл боловсруулах ажлын даалгавар өгнө.

Дадлага–2

Нэг малчдын бүлэг, хэсгийн өвөл хаврын улирлын бэлчээрт хийсэн мониторингийн судалгааны сүүлийн 3 жилийн тоон үзүүлэлт болон фото зургийн хамт кэйс болгон сургалтад орлолцогчдод үзүүлж үр дүн болон зураг тус бүр дээр ажиглалт судалгаа хийж хамтран ярилцаж дүн шинжилгээ хийнэ.

2. Малын тэжээллэг, арчилгаа, маллагаанд тавих шаардлага

Эрс тэс ширүүн уур амьсгалтай манай оронд дулаан хүйтний хэлбэлзэл, байгалийн бэлчээрийн ургац, түүний шимт чанарын өөрчлөлт зэргээс шалтгаалан хаана өвөлжих, хаваржих, зусах, намаржихаа шийдэж малынхаа хариуллага, маллагааг зохицуулдаг. Малчин та дараах сэдвээр өөрийн санал бодлоо хуваалцана уу? Үүнд:

- Урин дулааны үед өөрийн ашигладаг бэлчээрийн болон сум, багийн нутагт ургадаг малын тэжээлийн гол гол ургамлуудыг нэрлэх?,
- Бэлчээрийн ургамлын төрөл, ургацын байдлаар сэлгэн нүүдлэж, нэг нутаг буурийн бэлчээрийг өглөө, орой, өдрийн халуунд гэх маягаар хуваарилан хариулж малладаг эсэх?,
- Урин дулааны үед бэлчээрийн ногоо шүүс ихтэй байдаг ч малаа өдөрт нэг удаа бага үдийн алдад бэлчээрээр усалдаг байхын ач холбогдол?,
- Монгол мал ерөнхийдөө таруу идээшлэх дуртай байдгийг харгалзан хариулгаа хэрхэн тохируулах вэ?.

3. Малын эрүүл мэндийн чиглэлээр нэвтрүүлэх шаардлага



Мал эмнэлгийн байгууллагатай жил бүр гэрээ байгуулан хамтран ажиллаж, мал сүргээ малын эмчийн байнгын хяналтад байлгахын ач холбогдол юу вэ?


Хашаа, байрны ойр орчимд болон ашиглаж байгаа бэлчээрт үхсэн мал, амьтны хүүр, сэг зэмийг цуглуулж, устгахын зэрэгцээгээр гэрээт малын эмчээр халдваргүйтгэл хийлгэдэг байна гэж заасан байдаг тэгвэл танай өрх, хот айл энэ шаардлагыг биелүүлж байна уу?

Мал сүрэгтээ өдөр тутмын хяналт тавих бөгөөд малд өвчний шинж тэмдэг илэрснээс хойш 12 цагийн дотор сумын мал эмнэлийн байгууллагад мэдэгдэх ёстой. Тиймээс танай хот айл, малчин өрхүүд хэрхэн ажилладаг вэ?.

4. Малын нөхөн үйлдвэрлэл, үржүүлэг селекции

Сургалтыг дадлага ажил байдлаар бие биедээ туршлагаа дэлгэрүүлж, харилцан суралцах байдлаар зохион байгуулбал илүү үр дүнтэй тул уг сэдвийн хүрээнд 3–4 оролцогдыг багт хуваан, саналыг бичүүлэн, тайлбарлуулан, нийт оролцогчдын дунд хэлэцүүлэн дадлага ажил байдлаар зохион байгуулж болно. Багаас төлөөлөл гарч илтгэх, түүнийгээ тайлбарлах, мэдээллийн дагуу түлхүүр асуултыг бэлтгэж, асуудал дэвшүүлж, хэлэлцүүлэг зохион байгуулах гэх мэт байдлаар зохион байгуулах нь сургалтын үр дүнг сайжруулах боломжтой юм.


Тухайлбал: Экологийн бүс нутгуудад зонхилох төрлийн малын уламжлалт зохистой байршлын талаар хэлэлцүүлэх



Бүс нутаг дах нийт малын 51–ээс доошгүй хувийг тухайн төрлийн мал эзэлж байгааг зохистой гэж ойлгоно.
Тухайлбал:


- Ойт хээрийн бүсэд – Үхэр, хонь
- Өндөр уулын бүсэд – Сарлаг, ямаа
- Говь, цөлийн бүсэд – Тэмээ, ямаа
- Хээрийн бүсэд – Хонь, адуу

Унаган үүлдэр, омгийн бод мал үржүүлэх, зохистой бүс, бүслүүрийн талаар хэлэлцүүлэх



Монгол үүлдрийн адуу, тэмээ, үхэр, сарлагийг бүх бүс нутагт тархсан гэж ойлгоно

Унаган үүлдэр, омгийн бог мал үржүүлэх, зохистой бүс, бүслүүрийн талаар хэлэлцүүлэх




Монгол үүлдрийн хонь, ямааг бүх бүс нутагт тархсан гэж ойлгоно

5. Малын гаралтай түүхий эд бэлтгэлд тавих шаардлага

Багаас төлөөлөл гарч илтгэх, түүнийгээ тайлбарлах, мэдээллийн дагуу түлхүүр асуултыг бэлтгэж, асуудал дэвшүүлж, хэлэлцүүлэг зохион байгуулах гэх мэт байдлаар зохион байгуулах нь сургалтын үр дүнг сайжруулах боломжтой юм.

Тухайлбал: Түүхий эдийн гарал үүслийн түүхийг мөшгөх тогтолцооны талаар хэлэлцүүлэх



ДӨРӨВ. СУРГАЛТЫН ДАРААХ ДҮГНЭЛТ, ҮНЭЛГЭЭ

Чиглүүлэгч багш та сургалтыг дүгнэхдээ оролцогчидтой харилцан ярилцаж, тэдний санал бодлыг сонсон, сургалт хэр үр дүнтэй болсон талаар сэтгэгдлийг нь сонсохдоо дараах зүйлсийг анхаараарай. Үүнд:

- Оролцогчдын үзэл бодол, саналыг хүндэтгэх
- Хүн бүрийн үзэл бодол, санал, туршлагаа солилцох боломжтой сургалтын орчныг бүрдүүлэх
- Шаардлагатай тохиолдолд санал хүсэлтийг бичүүлж авах
- Ялгаатай үзэл бодол, санал туршлагыг үндэслэн бүлгийн хэлэлцүүлэг хийх
- Хүмүүсийн итгэл үнэмшил, туршлага, амьдралын хэв шинжид тулгуурлан сургалтыг зохион байгуулахыг бүү мартаарай. Сургалтын дараа санал сэтгэгдэл сонсох хугацаа гаргаж, үр дүнгийн талаарх чөлөөт ярилцлага зохион байгуулах нь илүү үр дүнтэй байдаг.

4.1 СУРГАЛТЫН ҮНЭЛГЭЭНИЙ ХУУДАС

Бидний зохион байгуулсан сургалтад идэвхтэй оролцсонд баярлалаа. Таны нэр энэхүү үнэлгээний хуудсанд дурдагдахгүй тул сургалтын талаарх санал бодлоо чөлөөтэй илэрхийлээрэй.

Сургалтын талаар сэтгэгдлээ илэрхийлнэ үү.

.....

Сургалтаар эзэмшсэн мэдлэг чадвараас танд хамгийн их хэрэг болохуйц зүйл юу байсан бэ?

.....

Сургалтын аль хэсэг танд хамгийн хэрэгтэй байсан бэ?

.....

Сургалтын аль хэсэг танд ач холбогдолгүй байсан бэ?

.....

Та сургалтаас сурсан зүйлсээ хэрхэн хэрэгжүүлэх вэ?

.....

Танд сургалтыг сайжруулж, өөрчлөх ямар нэгэн санал байна уу?

.....

Бусад:

.....

Сум /хороо:

Нас:

Хүйс:

Гарын авлагыг хэрхэн бүтээсэн талаар

2.2.1. Малын бэлчээрт тавих үндсэн шаардлага хэсгийг судлаач Л.Ганцогт. МБАНХ

2.2.2. Малын тэжээллэг, арчилгаа, маллагаанд тавих үндсэн шаардлагууд хэсгийг судлаач, зөвлөх инженер Б.Мэнджаргал МБАНХ

2.2.3. Малын эрүүл мэндэд тавигдах шаардлага хэсгийг судлаач С.Дивангар Дэлхийн банкны “МАН-н ЭЗЭН” төсөл

2.2.4. Малын нөхөн үйлдвэрлэл, үржүүлэг селекцид тавих үндсэн шаардлага хэсгийг судлаач Н.Ганхуяг МБАНХ

2.2.5. Малын гаралтай түүхий эд бэлтгэлд тавих үндсэн шаардлага хэсгийг судлаач А.Өнөрзул МНАДундын хоршоо

нар боловсруулсан бол сургалтын аргазүй, зохион байгуулалт, үнэлгээний хуудас хэсгийг боловсруулахдаа “Малчдын амьдрах ухааны чадварыг дэмжих, нийгмийн хамгааллыг өргөжүүлэх дэд хөтөлбөр”-ийн хүрээнд бэлтгэсэн “Ноос, ноолууран бүтээгдэхүүний үйлдвэрлэл, технологи” сэдэвтэй сургагч багшид зориулсан гарын авлагаас санаа авсан болно.

Гарын авлагын талаар санал зөвлөмжөө бидэнд ирүүлээрэй, хамтран ажилласан бүх хүмүүстээ баярлалаа